

“Үйл явдал” НОМ

1-р хичээл

“Үйл явдал” номын үндэс
суурь

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 by Гурав дахь мянган үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Энэхүү материалыг 2007 онд Ийгли ТВ-н Христийн Нэвтрүүлгийн албанд орчуулсан бөгөөд Библийн зарим эшлэлүүдийг Монголын Библийн Нийгэмлэгийн Шинэ Гэрээ©1990 номноос зохиогчийн зүгээс Ийгл ТВ-ын Христийн нэвтрүүлгийн албанд өгсөн зөвшөөрлийн дагуу оруулсан. Библийн бусад эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи ©2004-ээс авлаа.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүй.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Агуулга

УДИРТГАЛ	1
Зохиогч	1
Луухын бичсэн сайн мэдээ	2
Илэрхий.....	3
Далд.....	3
Эхэн үеийн Христийн сүмийн түүх	4
Гар бичмэлүүд.....	4
эртний сүмийн удирдагчид	5
Шинэ Гэрээ.....	6
Учиг сэжүүр.....	6
Луух.....	7
Түүхэн орчин	8
Он	9
МЭ-ний 70 оноос хойш	9
МЭ-ний 70 оноос өмнө	10
Анхны уншигчид	11
Төфил.....	11
Өргөн олон уншигч.....	12
Нийгмийн байдал.....	12
Ромын Эзэнт улс	13
Еврейчүүд	14
Теологийн үндэс суурь	17
Хуучин Гэрээ.....	17
Түүх	17
Израйль	19
Ертөнцийн Эзэний хаант улс.....	22
Еврейн теологи.....	22
Усаар угаан батлагч Жоган	23
Христэд итгэгчдийн теологи.....	24
Луухын бичсэн сайн мэдээ	26
Есүс.....	26
Төлөөлөгчид	27
ДҮГНЭЛТ	29
ТАЙЛБАР ТОЛЬ	31

“Үйл явдал” ном

Нэгдүгээр хичээл

“Үйл явдал” номын үндэс суурь

УДИРТГАЛ

Германы агуу их хөгжмийн зохиолч Людвиг ван Бетховен гайхалтай чадварлаг бичсэн хөгжмийн зохиолуудаараа дэлхий даяар дурсагдсан хэвээр л байна. Хэдийгээр Бетховены хөгжмийн бүтээлүүд гайхалтай сайхан боловч, тэрбээр хар залуугаасаа сонсголоо аажмаар алдаж байсан гэдгийг санах үед энэ бүхэн улам бүр сэтгэл татам болдог билээ. Үнэнийг хэлэхэд Бетховен хамгийн шилдэг бүтээлүүдээ таг дүлий байхдаа бичсэн гэдгийг ухаарах мөчид энэ бүгд туйлын гайхалтай болдог. Бетховены амьдралын нөхцөл байдлыг мэдэх нь түүний хөгжмийг улам бүр сэтгэл татам болгож байна.

Тэгэхлээр Библийг таашаан эрхэмлэх нь Бетховеныг таашаан эрхэмлэж байгаатай төсөөтэй байна. Библийн янз бүрийн номноос Ертөнцийн Эзэн оршин байгааг тунхаглаж буй хүч чадал, тов тодорхой байдлыг олж харахад тийм ч хэцүү биш ээ. Харин бид Библийн зохиогчдын нөхцөл байдал, тэдний ертөнц, амьдрал ахуй, зорилгын талаар олж мэдэх үед Ертөнцийн Эзэний үгийг ойлгох ойлголт, үүнийг таашаан үзэх үнэлэлт маань улам гүнзгий болдог ажээ.

Энэ бол “Үйл явдал” номоор заах цуврал хичээлийн маань эхнийх нь юм. Бид энэ цуврал хичээлээр Шинэ Гэрээний тавьдахь ном болох “Есүсийн төлөөлөгчдийн хийсэн үйл явдал” буюу зүгээр л “Үйл явдал” гэж ихэвчлэн нэрлэдэг номыг судлах болно. Энэ хичээлдээ “Үйл явдал” номын үндэс суурь” гэдэг гарчиг өглөө. Энэ номонд гарах сургаалийг илүү тодорхой гүн гүнзгий ойлгож, улам илүү таашаан хүртэхэд тус болох нэлээд хэдэн асуудлыг бид үзэх болно.

Бидний үзэх энэ хичээл маань “Үйл явдал” номын үндэс суурьтай холбоотой гурван чухал асуудлыг хөндөнө. Нэгдүгээрт, бид уг номын зохиогч хэн болох талаар судлана. Хоёрдугаарт, түүхэн орчин нөхцөлийг нь судлана. Харин гуравдугаарт, теологийн үндэс суурийг нь судлах болно. За одоо бүгдээрээ “Үйл явдал” номын зохиогчийн талаар үзэж эхэлцгээе.

ЗОХИОГЧ

Бичээст багтах бүх номын адил Үйл явдал номыг Ариун Сүнсний оролцоотойгоор бичсэн юм. Гэхдээ энэ ер бусын оролцоо нь хүмүүн зохиогчид тавих бидний анхаарлыг сулруулах ёсгүй билээ. Ариун Сүнс Библийн эх бичгийг ямар нэгэн алдаа орохоос сэргийлж чаддаг ч гэсэн энэ бүх номыг бичсэн хүмүүн зохиогчдын хувь хүний онцлог шинж, боловсрол мэдлэг, санаа бодлыг бас ашигладаг юм.

Уламжлал ёсоор Үйл явдал номыг Сайн мэдээний гурав дахь номын зохиогч болох Луухтай холбон авч үздэг. Гэвч Сайн мэдээний гурав дахь номд ч, Үйл явдал

номд ч зохиогчийн нэрийг онцгойлон дурдаагүй байдаг. Тиймээс бид одоо эдгээр номын зохиогч нь Луух гэдгийг баталсан уламжлалт үзэл бодлын учир шалтгаануудыг судалж үзэх болно.

Бид Үйл явдал номын зохиогчийн талаарх гурван хэтийн төлөвийг судлана. Эхлээд бид Үйл явдал номыг Луухын бичсэн сайн мэдээний номтой харьцуулна. Дараа нь бид эхэн үеийн Христийн сүмийн түүх болон уг түүх Луухын зохиогчийн эрхийг хэрхэн гэрчилж байгааг үзнэ. Тэгээд гуравдугаарт бид эдгээр номыг Луух бичсэнийг заасан Шинэ Гэрээний бусад талыг товчхон судлана. За одоо бүгдээрээ Луухын бичсэн сайн мэдээний номноос Үйл явдал номын зохиогчийн тухай юу сурч болох талаар олж мэдэцгээе.

ЛУУХЫН БИЧСЭН САЙН МЭДЭЭ

Бид Үйл явдал номыг Сайн мэдээний гурав дахь номтой харьцуулж байхад эдгээрийг нэг хүн бичсэн юм байна гэдгийг нэлээд хүчтэй илэрхийлэх хоёр төрлийн нотолгоо гарч ирдэг. Нэг талаар, хоёр номонд хоёулаа энэ чиг рүү шууд зааж байгааг илэрхий өгүүлсэн мэдээлэл байдаг. Нөгөө талаар мөн энэ хоёр номын хэлбэр маяг, агуулга нь ижил төстэй болохыг харуулсан далд нотолгоо ч байдаг. Тэгэхлээр бүгдээрээ энэ хоёр номын зохиогч нь нэг хүн гэдгийг харуулах илэрхий нотолгоог үзэж эхэлцгээе.

Илэрхий

Бид Үйл явдал номын 1-р бүлгийн 1-р ишлэлд буй удиртгал хэсэгт:

Эрхэм хүндэт Тёфил ээ! Би анхны номдоо Есүс ажлаа эхэлсэн цагаасаа хойш Ертөнцийн Эзэн рүү буцах хүртлээ юу хийж, хүмүүст юу зааж байсныг бичсэн билээ (Үйл явдал 1:1).

Энд зохиогч наад зах нь хоёр боть ном бичсэний хоёр дахь нь Үйл явдал ном гэсэн утгаар “анхны ном”-ынхоо талаар өгүүлжээ. Мөн тэрбээр энэ номыг Тёфил хэмээх нэгэн эрхэмд хандан бичсэн гэдгээ ч харуулсан байна. Тэгвэл одоо яг үүнтэй төстэй удирдтгал хэсэг Луухын 1-р бүлгийн 1-ээс 4-т:

Гүнээ хүндэт Тёфил ээ! Есүс Христийн бүтээсэн гайхамшгийг үзсэн хүмүүс энэ тухайгаа бидэнд ярьж өгснөөр барахгүй зарим нь бүр ном бичжээ. Би олон жил үүнийг сайн судалсан учраас сонссон бүхэн чинь үнэн болохыг танд ойлгуулахыг зорьж, тун сонирхолтой нэгэн өгүүлэлийг дэс дараалан бичиж өгье. Миний бичих зүйл гэвэл, . . . (Луух 1:1-4).

Дахиад л энэ хэсэгт Тёфил хэмээх нэгэн эрхмийн нэрийг дурдаж байна. Гэхдээ “өмнөх ном” гэсэн ямар нэгэн үг алга.

Тэгэхлээр Үйл явдал ном болон Сайн мэдээний гурав дахь номыг хоёуланг нь Тёфил хэмээх нэгэн эрхэмд зориулж бичсэн бөгөөд Үйл явдал номд “анхны ном”-ын талаар дурдсан байна. Зохиогч нь хоёроос доошгүй боть ном бичсэн бөгөөд Луухын сайн мэдээ нь эхний боть, харин Үйл явдал ном бол хоёр дахь боть гэдгийг энэ бүх баримт баттай нотолж байна. Үнэндээ бол эдгээр удиртгал хэсгийн хоорондын холбоо нь аливаа зохиолч хоёр боть бүтээл гаргахдаа хэрэглэдэг байсан эртний утга зохиолын ёсыг харуулж байгаа хэрэг юм. Жишээлбэл, Еврейн алдарт түүхч Иосиф Флавий “Апионы эсрэг” гэдэг бүтээлийнхээ хоёр ботид иймэрхүү өмнө үгийг бичсэн байдаг.

Эдгээр илэрхий холбоосоос гадна Үйл явдал ном болон Сайн мэдээний гуравдахь номын хооронд нэг зохиогчтой гэдэг санаа руу чиглүүлсэн далд уялдаа холбоо байдаг юм. Шинэ Гэрээ судлалын нэлээд хэдэн эрдэмтэн дээрх хоёр номын хоорондын адил төстэй байдлыг дурдсан байдаг. Хэдийгээр хичээлийн маань цаг бидэнд эдгээрийн талаар товч дурдах боломж олгож байгаа ч энэ хоёр ном нэг зохиогчтой болохыг баталсан далд нотолгоог хангалттай өгөх болно.

Далд

Бид Луух номын 1-р бүлгийн 1-ээс 4-т зохиогч маань Тёфил хэмээх эрхэмд нэгэн тэмдэглэлийг янз бүрийн эх сурвалжийг судалж дэс дараалан бичиж өгсөн тухайгаа дурдсан байдгийг харсан билээ. Тэгэхлээр Луухын сайн мэдээ ба Үйл явдал номын дараалал болон хэлбэр маяг нь ижил төстэй байгааг хэд хэдэн эрдэмтэн анзаарсанд гайхах зүйлгүй болов уу. Мөн энэ хоёр номын бүрэлдэхүүн хэсгийн бүтэц нь олон талаараа төстэй байдаг. Хоёулаа олон хэсгээс тогтсон хэлбэртэй, хуйлмал бичгийн жишиг болсон хэмжээг дүүргэсэн, барагцаалбал ижил хэмжээтэй байдаг.

Үүнээс гадна ном бүрд он дараалалын үргэлжлэх хугацаа ч хүртэл хоорондоо төстэй байна. Луухын сайн мэдээ болон Үйл явдал ном нь хоёулаа барагцаалбал ойролцоо тооны он жилийг хамарсан байдаг. Мөн энэ хоёр номын хооронд зэрэгцээ сэдвүүд гардаг. Зөвхөн нэг жишээ авч үзье. Луухын сайн мэдээнд Есүсийн аялал нь цаашдаа баривчилгаа, эрүү шүүлт, зовлон зүдгүүр, үхлээр үргэлжилж, Иудейн шашины нийслэл бөгөөд Еврейчүүдийн хаант засгийн эрх мэдэл төвлөрсөн Иерусалим хотод ялалт байгуулсанаар оргилдоо хүрдэг. Харин Үйл явдал номонд үүнтэй төстэй явдлыг Төлөөлөгч Пуулийн аялал Ром хотод өндөрлөж байгаагаар дүгнэсэн байдаг билээ. Энэ бүхэн түүнийг баривчилсанаар эхэлж, байцаан шийтгэж, зовоон шаналгаж, улмаар дэлхийн эзэнт улсын эрх мэдлийн төв нийслэл хотод Христийн ялгуусан сайн мэдээг тунхаглаж байгаагаар дуусдаг.

Үүнээс гадна энэ хоёр ном тус бүрт ижилхэн түүхийг хүүрнэдэг учраас эдгээрийн хооронд ижил төстэй байдал ажиглагддаг юм. Бидэнд Луухын сайн мэдээг уншиж байхад, энэ бүх түүх Үйл явдал номыг уншиж дууссаны дараа л бүрэн гүйцэд болох юм байна гэдэг нэг тиймэрхүү бодол төрдөг билээ. Жишээлбэл, Луухын сайн мэдээний эхэнд Ертөнцийн Эзэнд бат итгэлтэй Шимун гэгч нэгэн хүн

Есүсийг Еврей бус үндэстнүүдэд гэрэл болох тухай тунхагладаг. Луух 2-р бүлгийн 30-аас 32-т буй түүний үгийг сонсоцгооё. Тэнд:

Их Эзээн! Та өөрийн илгээсэн аврагчийг надад үзүүллээ. Энэ аврагч бол хорвоогийн гэрэл бөгөөд таны тухай сонсоогүй олон үндэстэнд үнэн замыг заан өгч, Иудейчүүдэд мөнхийн жаргал авчирна (Луух 2:30-32).

Луухын сайн мэдээнд өгүүлсэн Есүсийн үйлчлэл нь Ертөнцийн Эзэний аврал болон Израйльчуудад өгсөн амлалтыг тайлбарлаж байна. Гэвч бид зөвхөн Үйл явдал номноос л Еврей бус үндэстэнүүдэд гэрэл болох Ертөнцийн Эзэний амлалтыг нэлээд утга учиртай байдлаар хардаг. Эдгээр болон бусад ижил төстэй байдал нь энэ хоёр бүтээл авралын түүхийн талаар нийтлэг үзэл бодолтой бөгөөд нэг зорилго итгэл үнэмшилтэй байгааг зааж байна. Мөн эдгээр адил төстэй байдал нь бид нэг зохиогчийн хоёр ном үзэж байгааг хэлж байгаа хэрэг юм.

ЭХЭН ҮЕИЙН ХРИСТЭД ИТГЭГЧИД

Ийнхүү бид Үйл явдал ном болон Луухын сайн мэдээ нь нэг зохиогчтой болохыг баталсан хэдэн нотолгоо үзлээ. Тийм учраас одоо энэ тухай өгүүсэн эхэн үеийн Христэд итгэгчдийн түүхээс зарим нэг нотолгоог үзэхэд бэлэн болов. МЭ-ний хоёроос дөрөвдүгээр зууны үеийн Христэд итгэгчид Пуулийн аян замын хань Луух бол Үйл явдал ном ба Луухын сайн мэдээ хоёрын зохиогч гэдгийг баталсан байдаг. Бид энэ нотолгоог хоёр аргаар товчхон үзэх болно. Нэгдүгээрт, бид Библийн болон библийн тухай өгүүлсэн эртний гар бичмэлүүдийг судлана. Хоёрдугаарт, Луухын зохиогч болох талаар эхэн үеийн сүмийн удирдагчдын бичсэн зүйлийг үзнэ. За одоо эртний зарим нэг гар бичмэлд буй нотолгоог үзэж эхэлье.

Гар бичмэлүүд

1952 онд Египетээс олдсон Папирус 75 хэмээх маш эртний нэг гар бичмэлийг авч үзье. Энэ бол папирусан дээр бичсэн, бидэнд мэдэгдэж буй Шинэ Гэрээний маш эртний гар бичмэл дээрх нотолгоонуудын нэг юм. Үүнийг МЭ-ний 175-аас 200 оны үед хуулж бичсэн бөгөөд дотроо Луухын болон Иоганы сайн мэдээний нэлээд хэсгийг багтаасан аж. Эдгээр Сайн мэдээний номын бичвэрийн хооронд үүний агуулгын тухай өгүүлсэн хоёр тодорхойлолт байна. Эхнийх нь Луухын сайн мэдээний төгсгөл хэсгийн дараа залгаад “эвангелион ката Луакан” буюу “Луухын бичсэн сайн мэдээ” гэсэн үг юм. Харин энэ үгийн дараа “эвангелион ката Ионнан” буюу “Иоганын бичсэн сайн мэдээ” гэж бичсэн байна. Үүнээс харахад “Луухын бичсэн сайн мэдээ” гэсэн үгийн өмнөх материал бол Луухын сайн мэдээ мөн ажээ. Энэ гар бичмэл дээрх нотолгоо нь бүр эрт үеэс л Сайн мэдээний гуравдахь номыг Луух бичсэн гэж үзэж байсныг харуулж байна. Бүр цаашилбал энэ

бүхэн Луух бас Үйл явдал номыг зохиогч гэдгийг зааж байна.

Хоёрдугаарт, Италийн түүхч Мураторигийн олсон нэгэн баримтын тасархай нь МЭ 170-аас 180 оныг хамарсан байдаг. Энэ бол эхэн үеийн Христийн сүмийхэн Ертөнцийн Эзэний үг гэж хүлээн зөвшөөрсөн Шинэ Гэрээний номыг жагсаан бичсэн маш эртний баримт бичиг юм. Энэ бол эхэн үеийн Христийн сүмийхэн Ертөнцийн Эзэний үг гэж хүлээн зөвшөөрсөн Шинэ Гэрээний номыг жагсаан бичсэн маш эртний баримт бичиг юм. Энэ баримтанд Луухын сайн мэдээний зохиогч бол Луух мөн гэж батласаны дараа түүнийг мөн Үйл явдал номын зохиогч гэж тодорхой заасан байдаг. Уг баримтын 34-өөс 36-р мөрт:

Түүнээс гадна Есүсийн төлөөлөгчдийн хийсэн бүх үйлсийг нэг номонд багтаан бичжээ. . . Өөрийн эргэн тойронд болсон салангид үйл явдлуудыг Луухын эмхтгэж бичив.

Энэ бүхэн 2-р зууны үед Луух бол Үйл явдал номын зохиогч бөгөөд уг номонд гарсан зарим нэг үйл явдлыг өөрийн нүдээр харсан гэж маш олон хүн үзэж байсныг харуулж байна.

Гуравдугаарт, МЭ-ний 160-аас 180 оны үед бичигдсэн Маркионы эсрэг оршил үг хэмээх баримт бичгийн Сайн мэдээний гуравдахь номын оршил хэсэгт Луух болон Үйл явдал номын зохиогчийг:

Ариун Сүнсэнд хөтлөгдсөн Луух энэ Сайн мэдээний номыг бүгдийг нь туурвижээ. . . Тэгээд нөгөө л Луух Есүсийн төлөөлөгчдийн хийсэн Үйл явдал номыг бичсэн юм.

Бидэнд эртний энэ гар бичмэл дээрх нотолгооноос гадна Луухыг Гуравдахь сайн мэдээ болон Үйл явдал номыг зохиогч болохыг баталсан эхэн үеийн Христийн сүмийн удирдагчдын гэрчлэл бас байдаг.

эртний сүмийн удирдагчид

МЭ-ний 130-аас 202 оны үед амьдарч байсан Христийн сүмийн эцэг гэгдэх Иринея гэдэг хүн Гуравдахь сайн мэдээний зохиогч нь Луух гэдэгт итгэдэг байжээ. Тэрбээр Тэрс үзлийн эсрэг хэмээх зохиолынхоо 3-р дэвтрийн 1-р бүлгийн 1-р хэсэгт:

Мөн Пуулийн найз Луух гэгч түүний номлосон сайн мэдээг ном болгож бичсэн.

Энд Иринея Үйл явдал бол Пуулийн номлосон Сайн мэдээг бичиж тэмдэглэсэн ном юм гэж хэлсэн байна. Иринея бол Үйл явдал номын зохиогч нь Пууль гэдгийг анх мэдэх боломжтой хүн гэж түүхийн нэлээд сайн эх сурвалжид өгүүлдэг учраас түүний хэлсэн үгийн маш чухал гэж үздэг.

МЭ-ний 150-аас 215 оны үед амьдарч байсан Христэд итгэгч теологич

Александр хотын Климент мөн Луухыг Үйл явдал номын зохиогч гэж хэлсэн байдаг. Тэрбээр Стромата буюу янз бүрийн зүйлийн тухай бичсэн бүтээлийнхээ 5-р дэвтрийн 12-р бүлэгт:

Есүсийн төлөөлөгчдийн хийсэн үйл явдалд гардаг Луух нь 'Афинчууд аа! Би танай хотоор явж, та нарын шүтдэг бурхдыг харж, их сүсэгтэйг чинь мэдлээ' гэж Пуулийн хэлсэнтэй холбоотой билээ.

Мөн МЭ-ний 155-иас 230 оны үед амьдарч байсан Тертуллиан гэгч Маркионы эсрэг гэдэг бүтээлийнхээ 4-р дэвтрийн 2-р бүлэгт:

Тийм учраас төлөөлөгч Иоган, Матай нар эхлээд бидэнд Есүст итгэх итгэлийг заасан. . . Харин дараа нь Луух, Маарх нар үүнийг шинэчилж заасан юм.

Энд Тертуллиан Гуравдахь сайн мэдээг онцгойлон Луухтай холбож байна.

Эцэст нь МЭ-ний 323 оны орчим сүмийн агуу түүхч Евсевий өөрийн бичсэн *Христийн сүмийн түүх* номынхоо 1-р дэвтрийн 5-р бүлгийн 3-р хэсэгт Луухыг Үйл явдал номын зохиогч гэж дурдсан байдаг билээ. Тэрбээр энэ номдоо:

Луух . . . Үйл явдал номонд [хүн амын тооллогын талаар] дурджээ.

Иймэрхүү баталсан үгсээс гадна, хэдийгээр Луухыг Есүсийн төлөөлөгчдийн нэг гэж ер дурдаагүй боловч, эхэн үеийн Христийн сүмийн ном зохиолуудад Гуравдахь сайн мэдээ болон Үйл явдал номыг түүнээс өөр хүн бичсэн гэж огт дурдаагүй нь гайхалтай билээ. Тийм учраас иймэрхүү учиг сэжүүрээс, эхэн үеийн Христэд итгэгчид Луух бол дээрх номнуудын зохиогч мөн гэдгийг санаанаасаа зохиож гаргаагүй гэдэгт итгэх учир шалтгаан бидэнд байна. Тэд зөвхөн эдгээр номыг Луух бичсэн гэдэг үнэнийг л дамжуулсан юм.

Шинэ Гэрээ

Ийнхүү бид Үйл явдал ном болон Гуравдахь сайн мэдээний зохиогч нь нэг хүн гэдгийг баталсан нэлээд нухацтай шалтгаан байдгийг үзлээ. Түүгээр ч барахгүй энэ нэг зохиогч маань Луух мөн гэдгийг эхэн үеийн Христэд итгэгчид ч гэсэн гэрчилж байна. За тэгвэл бид Шинэ Гэрээний бусад хэсгээс Луухын өөрийнх нь тухай ямар дүгнэлт хийж болохоо үзэцгээе.

Бид энэ нотолгоог хоёр аргаар шинжиж үзнэ. Нэгдүгээрт, бид энэ нэр нь үл мэдэгдэх зохиогчийн талаар Шинэ Гэрээнээс зарим нэг учиг сэжүүр гаргаж ирнэ. Хоёрдугаарт, бид эдгээр учиг сэжүүрийг Луухын тухай өөрсдөдөө байгаа мэдээлэлтэй харьцуулж үзэх болно. Эхлээд бүгдээрээ энэ зохиогчийнхоо тухай зарим нэг учиг сэжүүрийг харьцгаая.

Учиг сэжүүр

Үйл явдал номын зохиогч нь өөрийнхөө нэрийг хэлээгүй гэдгийг бид аль хэдийн мэдсэн. Тэрбээр ивээн тэтгэгч Тёфилийнхээ тусын тулд өөрийнхөө нэрийг хэлэх шаардлагагүй гэж үзсэн бололтой. Луухын 1-р бүлгийн 3-т тэрбээр, “. . . сонссон бүхэн чинь үнэн болохыг танд ойлгуулахын зорьж . . .” гэсэн байдаг, Харин Үйл явдал номын 1-ийн 1-т, “*Би анхны номдоо . . . бичсэн билээ*” гэжээ. Энэ ивээн тэтгэгч өөрийг нь хэн болохыг сайн мэднэ гэж зохиогч үзжээ. Харин энэ бүхэн Тёфилд төвөг учруулаагүй боловч, орчин үеийн уншигчдад их асуудал гаргаж ирсэн юм.

Үүнтэй зэрэгцээд Шинэ Гэрээний нэлээд хэдэн зүйл зохиогчийн тухай бидэнд хэлж өгдөг. Нэгдүгээрт тэрбээр Есүсийн төлөөлөгч биш байв. Үнэндээ тэрбээр Есүсийг тэнгэрт одсоны дараа Түүнд итгэсэн бололтой. Луухын сайн мэдээ номын 1-р бүлгийн 1, 2-р ишлэлд ингэж нарийвчлан бичсэн байна:

Луухаас Тёфилд бичсэн захианд: - Гүнээ хүндэт Тёфил ээ! Есүс Христийн бүтээсэн гайхамшгийг үзсэн хүмүүс энэ тухайгаа бидэнд ярьж өгснөөр барахгүй зарим нь бүр ном бичжээ (Луух 1:1-2).

Зохиогч “Есүсийн амьдралын үйл явдлыг үзсэн хүмүүс энэ тухайгаа бидэнд ярьж өгсөн” гэж хэлснээрээ Есүсийн амьдралыг нүдээр үзсэн хүмүүсийн дунд байгаагүй гэдгээ харуулж байна.

Хоёрдугаарт, Үйл явдал ном болон Луухын сайн мэдээг бичсэн Грек хэлний найруулга нь эдгээрийг бичсэн зохиогч сайн боловсрол эзэмшсэн болохыг харуулдаг. Шинэ Гэрээний олон ном Грек хэлний нэлээд түгээмэл, түүгээр ч барахгүй нь тун энгийн найруулгатай байдаг. Харин Луухын сайн мэдээ болон Үйл явдал ном тухайн хэлний нэлээд нарийн тансаг найруулгаар бичигдсэн болох нь харагддаг.

Гуравдугаарт, Үйл явдал номын хоёр дахь хэсгээс тухайн зохиогч Пуулийн аян замын ойр дотно нөхдийн нэг байсан гэдэг нь харагддаг. Үйл явдал номын эхний бүлгүүдэд хүүрнэл хэсгүүд нь гол төлөв 3-р биеэн дээр байдаг. Харин уг номын 16-р бүлгээс эхлээд хүүрнэл хэсгүүд нь заримдаа “бид”, “бидний” гэх зэргээр 1-р биеэн дээрээс өгүүлдэг. Бид ингэж 1-р биеэн дээрээс өгүүлсэн хэсгийг Үйл явдал номын 16-р бүлгийн 10-аас 17-р ишлэл, 20-р бүлгийн 5-аас 15-р ишлэл, 21-р бүлгийн 1-ээс 18-р ишлэл, мөн 27-р бүлгийн 1-ээс 28-р бүлгийн 16-р хүртэлх ишлэлээс тус тус харж болно.

Тухайн зохиогч Пуулийн авралын зарын сүүлчийн аялал болон түүний Цезаре хотоос Ром хүртэлх аянд хамт явсан гэдэг нь дээрх ишлэлүүдээс харагддаг.

Ийнхүү бид зохиогчийн талаар зарим нэг сэжүүр гаргаж ирлээ. Мөн энэ бүх нарийн ширийн зүйлс бидний мэдэх Луухтай хэрхэн сайн тохирч байгааг ч харлаа.

Луух

За одоо бүгдээрээ Луухын сайн мэдээ болон Үйл явдал номын зохиогчийн

талаар олж мэдсэн зүйлээ дахин нэг дурдъя. Тэрбээр Есүсийн төлөөлөгч биш, нэлээд сайн боловсрол эзэмшсэн бөгөөд Пуулийн аян замын хань байв. Энэ бүх нарийн ширийн зүйлийг бидний мэдэх Луухтай хэрхэн харьцуулах вэ? За байз. Юуны өмнө Луух бол Есүсийн төлөөлөгчийн нэг байгаагүй. Төлөөлөгчид нь Христийн сүмд гол үүрэг гүйцэтгэсэн билээ. Тэд сүмийг байгуулж, алдаа мадаг гай зовлонгоос хамгаалахын тулд Христийг төлөөлж хосгүй эрх мэдлээ ашиглаж байлаа. Үйл явдал номын 1-р бүлгийн 21, 22-т бичсэнээр бол Төлөөлөгчдийг Есүс өөрөө сургасан байдаг. Харин Луух Есүстэй огт хувьчлан уулзаж байгаагүй бөгөөд хэзээ ч Түүний төлөөлөгчдөд хамаарах эрх мэдлийг өөртөө хамаатуулж байгаагүй билээ. Тэрбээр зөвхөн Пуулийн авралын зар тараах үйл хэргийг үнэнчээр дэмждэг сүмийн энгийн нэг гишүүн л байсан юм. Луух нь Төлөөлөгчдөд тусалдаг байв. Пууль түүнийг Филээмөнд бичсэн захидлынхаа 24-р ишлэлд төлөөлөгчдийн адил “Есүсийн тухай миний хамт тунхаглагч” гэж нэрлэсэн байдаг.

Хоёрдугаарт, Луух нэлээд сайн боловсрол эзэмшсэн хүн байсан бололтой. Холосас 4-р бүлгийн 14-т түүнийг Пууль эмч гэж тодорхойлсоноос бид ийм дүгнэлт хийж болно. Хэдийгээр Шинэ Гэрээний үед өнөөгийнх шиг анагаах ухааны албан ёсны сургалт олгодоггүй байсан ч эмч болох хүнээс авъяас билэг, ур чадвар их шаарддаг байсан юм.

Гуравдугаарт, Луух нь Пуулийн аян замын хань болж байв. Төлөөлөгч Пууль Луухыг өөртэй нь хамт аялаж байсан тухай Холосасын 4-р бүлгийн 14, 2-р Тимот 4-р бүлгийн 11 болон Филээмөнд бичсэн захидлын 24-р ишлэлд тус тус дурдсан байдаг.

Тэгэхлээр бид Үйл явдал номын зохиогч нь хэн болох тухай асуудлыг дараах байдлаар хураангуйлж болно. Луух бол Үйл явдал номын зохиогч мөн гэдэгт чиглүүлсэн нэлээд олон түүхэн нотолгоо байна. Луухын сайн мэдээ болон Үйл явдал ном нэг л зохиогчтой юм байна. Эхэн үеийн Христэд итгэгчид үргэлж Луухыг эдгээрийн номын зохиогч гэж үзэж байжээ. Библийн мэдээлэл ч хүртэл энэ санааг тууштай дэмждэг. Бид энэ бүх нотолгооноос улбаалаад Луух бол Үйл явдал болон Сайн мэдээний гуравдахь номын зохиогч мөн гэдэгт итгэх нэлээд дориун шалтгаантай болж байна. Мөн Луух нь өөрийнхөө бичиж тэмдэглэсэн асуудалтай их ойр байж, үүнтэй холбоотой материалтай танилцах нэлээд боломжтой байсан гэдгийг бид үргэлж санаж байх хэрэгтэй.

ТҮҮХЭН ОРЧИН

Ийнхүү бид Луухын зохиогчийн байр суурийг үзсэн тул одоо Үйл явдал номын түүхэн орчин нөхцөлийн тухай судлахад бэлэн боллоо. Луух үүнийг хэзээ бичсэн бэ? Хэнд зориулж бичив ээ?

Бид Үйл явдал номын түүхэн орчинг судлахдаа гурван зүйлийг анхаарах болно. Эхлээд бид Үйл явдал номыг Луух хэзээ бичсэнийг мөшгөн судалж, бичсэн оныг нь мэдэж авна. Дараа нь бид уг номын анхны уншигчид хэн болохыг шинжлэнэ. Эцэст нь эдгээр уншигчдын нийгмийн байдлыг судлана. Эдгээр асуудлыг судлах нь энэ бүх хүүрнэсэн үйл явдалтай Луух ойр байсан эсэхийг

тодруулахад бидэнд туслах болно. Мөн эдгээр нь манай эриний 1-р зууны үед Христийн тухай сайн мэдээ ямар үр нөлөө үзүүлсэнийг гүн гүнзгий бүрэн гүйцэд ойлгоход маань туслана. Одоо бүгдээрээ энэ номыг бичсэн оныг судалж эхэлцгээе.

Он

Хэдийгээр Үйл явдал номыг анх хэзээ бичсэн талаар олон янзын үзэл бодол байдаг ч ерөнхийдөө бид энэ асуудлаар Шинэ Гэрээний эрдэмтдийн баримталдаг үзэл бодлыг хоёр үндсэн чиг хандлагад хувааж болно. Нэг хэсэг хүмүүс Луух энэ номыг Иерусалим хотод буй Ертөнцийн Эзэний сүмийг нураан сүйтгэсэн МЭ-ний 70 оноос хойш бичсэн гэж маргадаг. Харин өөр нэг хэсэг хүмүүс түүнийг энэ номоо Иерусалимын сүмийг нураан сүйтгэсэн МЭ-ний 70 оноос өмнө бичсэн гэж үздэг. МЭ-ний 70 онд болсон энэ эмгэнэлт явдал нь Еврейчүүдийн түүхэнд чухал үйл явдал болсон юм. Тийм учраас эдгээр үйл явдалтай холбоотой үзэл бодлыг эргэцүүлэн тунгаах нь тустай байдаг. Бид дээрх үзэл бодол бүрийг судлана. Эхлээд Луух Үйл явдал номыг МЭ-ний 70 оноос хойш бичсэн байх боломжтой эсэхийг үзнэ.

МЭ-ний 70 оноос хойш

Үйл явдал номыг МЭ-ний 70 оноос хойш бичсэн гэдэг үзлийг баримталдаг эрдэмтэд нэлээд хэдэн зүйлийг харгалзан үздэг. Жишээлбэл, олон эрдэмтэн Үйл явдал номонд гарч буй өөдрөг үзэл нь уг номыг МЭ-ний 80-аас 90 оны хооронд бичсэнийг харуулж байна гэгцгээдэг. Энэ үзлээр бол эхэн үеийн Христэд итгэгчдийн тухай ийм эрт бичих нь хэтэрхий эерэг хандлага юм. Харин энэ бол эхэн үеийн Христэд итгэгчдийн талаар өнгөрснийг эргэн санагалзаж байгаа хэрэг бөгөөд ингэх нь тухайн үйл явдлаас олон жилээр тусгаарлагдахыг шаардаж байгаа ажээ. Гэвч энэ үзэл бодол нь Христэд итгэгчдийн дотор болон гадна талд бий болсон олон янзын төвөгтэй асуудлыг Үйл явдал номонд эрүүл арга замаар хэрхэн шийдвэрлэж байсныг үл тоомсорлож байна.

Үйл явдал номыг МЭ-ний 70 оноос хойш бичсэн гэж үздэг хүмүүс голдуу энэ номын зарим материал нь Еврейн түүхч Иосифийн бүтээлтэй холбоотой гэж үздэг юм.

Иосифын бүтээлүүд нь МЭ-ний 79 оны үед бичигдсэн бөгөөд энэ бүхэнтэй МЭ-ний 85 оноос өмнө олон нийт танилцах боломж бараг байхгүй байжээ. Тийм учраас Үйл явдал номыг түүхч Иосифын бүтээлээс хамааралтай гэж үздэг хүмүүс үүнийг МЭ-ний 79 оноос өмнө бичигдэх боломжгүй бөгөөд МЭ-ний 85 оны үед л бичигдсэн байх гэсэн дүгнэлт хийсэн байдаг.

Хэдийгээр энэ байр суурийг баримталдаг хүмүүс Үйл явдал ном болон Иосифын бүтээлийн хооронд олон хэлхээ холбоо байгааг заадаг боловч бид эдгээрээс зөвхөн дөрвийг нь авч үзэх болно.

Нэгдүгээрт, Үйл явдал номын 5-р бүлгийн 36-д Еврейн босогч Түүд гэгчийн тухай гардаг. Мөн энэ хүний тухай түүхч Иосифын бичсэн Еврейн эртний түүхэн

тэмдэглэлийн 20-р дэвтрийн 97-р хэсэгт дурдсан байдаг байна. Хоёрдугаарт, Үйл явдал номын 5-р бүлгийн 37-д Галил аймгийн Иудас гэгч этгээд бослого гаргасан тухай өгүүлдэг. Харин түүний тухай түүхч Иосифын бичсэн “Еврейчүүдийн дайн” номын 2-р дэвтрийн 117, 118-р хэсэгт, мөн түүний “Еврейн эртний түүхэн тэмдэглэл”-ийн 18-р дэвтрийн 1-ээс 8-р хэсэгт дурдсан байдаг ажээ. Гуравдугаарт, Үйл явдал номын 21-р бүлгийн 38-д үймээн гаргасан нэгэн Еврей хүний тухай өгүүлдэг. Энэ хүний тухай мөн Иосифын бичсэн “Еврейчүүдийн дайн” номын 2-р дэвтрийн 261-ээс 263-р хэсэгт, “Еврейн эртний түүхэн тэмдэглэл”-ийн 20-р дэвтрийн 171-р хэсэгт дурддаг байна. Дөрөвдүгээрт, Библийн нэлээд хэдэн тайлбарлагч Үйл явдал номын 12-р бүлгийн 19-ээс 23-д гарах Хэрэд Агрип хааны үхлийн тухай баримт нь Иосифын “Еврейн эртний түүхэн тэмдэглэл”-ийн 19-р дэвтрийн 343-аас 352-т буй хэсэгтэй хамаатай гэж маргадаг.

Хэдийгээр иймэрхүү учир шалтгааныг дагадаг Библийн олон тайлбарлагч байдаг ч, бид Үйл явдал ном болон түүхч Иосифын бүтээлийн хоорондох ижил төстэй хэсгүүд нь Үйл явдал ном нь Иосифын зохиолоос хамаарч байгааг батлахгүй гэдгийг зааж өгөх хэрэгтэй. Үнэнийг хэлэхэд Үйл явдал номонд гарч буй бүхний тодорхойлолт нь Иосифын бичсэнээс ялгаатай байдаг юм. Тэгэхлээр Үйл явдал ном болон Иосифын бүтээл нь олон түмний сайн мэдэх түүхэн үйл явдлуудыг тус тусдаа тоочсон эсвэл хоёулаа нэг эх сурвалжийг ашигласан байна гэвэл илүү үнэнд нийцэх болов уу. Нэгэнт л энд дурдсан хүмүүс нь харьцангуй алдартай түүхэн бие хүмүүс байсан учраас тэдний тухай хэд хэдэн түүхэн эх сурвалжид дурсан бичсэн нь тийм их гайхаад байх зүйл биш билээ. Түүнээс гадна бидний ярилцаж буй энэ Түүд гэдэг нэр бол тухайн үед их түгээмэл байсан юм. Энд нэг адилхан нэртэй хоёр өөр хүний тухай байх магадгүй.

МЭ-ний 70 оноос өмнө

Үйл явдал номыг бичсэн оны талаар өөр нэг баримталдаг гол үзлээр үүнийг Иерусалимын сүмийг нураан сүйтгэсэн МЭ-ний 70 оноос өмнө бичсэн гэж үздэг. МЭ-ний энэ эхэн үеийг дэмжсэн олон нотолгоо байдаг. Гэхдээ энэ удаа Үйл явдал номын сүүлчийн хэсгээс ямар дүгнэлт хийхэд л гол анхаалаа хандуулах нь бидний зорилго байх болно.

Одоо Үйл явдал номын хамгийн сүүлчийн хоёр ишлэл болох 28-р бүлгийн 30, 31-ийг сонсоцгооё. Тэнд Луух ингэж бичжээ:

Пууль хоёр жил байрны хөлс төлж, ирсэн бүх хүнийг хүлээн авч, Ертөнцийн Эзэний ер бусын улс болон Есүс Христ Их Эзэний тухай зоригтойгоор тунхаглахад хэн ч түүнийг хориглосонгүй ээ (Үйл явдал 28:30-31).

Пууль Ром хотод гэрийн хорионд орж, Христийн тухай сайн мэдээг зоригтой тунхаглаж байгаа тухай өгүүлсэнээр Үйл явдал ном өндөрлөв. Ингэж төгсөж байгаа нь Үйл явдал номыг МЭ-ний 70 оноос өмнө бичсэн гэдэгт итгэж болох маш чухал нотолгоо болжээ.

Учир нь нэгдүгээрт, Пуулийн үйлчлэлийн тухай Луухын бичсэн тэмдэглэл нь МЭ-ний 64 онд болсон нэгэн айхавтар хэргийн өмнөхөн дуусаж байна. МЭ-ний 64 онд Ромын эзэн хаан Нерон гэгч Христэд итгэгчдийг Ром хотод гал тавьсан гэж буруутгаж олон зуугаар нь алж эхлэв. Хэрэв Луухыг Үйл явдал номыг бичиж байх үед ийм маш том хэрэг явдал гарсан юм бол тэрбээр энэ тухай огт дурдахгүй байгаа нь туйлын хачирхалтай хэрэг билээ.

Хоёрдугаарт, олон хүн Пуулийг итгэлээсээ болоод Нерон хаан Христэд итгэгчдийг хавчиж байх үед буюу МЭ-ний 65 он эсвэл үүний дараахан алагдсан гэж үздэг. Хэрэв Үйл явдал номыг үүний дараа бичсэн юм бол уг номын гол баатрын нэг болох Пууль Есүст итгэнээсээ болж бусдад алагдсан талаар заавал дурдах ёстой байсан билээ.

Гуравдугаарт, МЭ-ний 70 онд Иерусалим хот дахь Еврейчүүдийн гол сүмийг устгасан явдал нь Христэд итгэгчдийн дунд буй Еврей болон Еврей бус хүмүүсийн харилцаанд маш ноцтой нөлөөлсөн байх ёстой. Тэгээд ч Үйл явдал номын олон хэсэг тэдний хоорондын харилцаанд гол анхаарлаа хандуулсан байдаг билээ. Тэгэхлээр Үйл явдал номонд Иерусалимын энэ сүмийн сүйрлийн талаар огт оруулаагүй нь тун үнэмшилгүй санагдаж байна.

Иймэрхүү баримтуудаас харвал Луух Үйл явдал номыг энэ номонд дурдсан сүүлчийн түүхэн хэсэг болох МЭ-ний 60-аас 62 онд Пууль Ром хотын шоронд сууж бусдад Есүс Христийн тухай ярьж байсан үед л бичиж дуусгасан гэж дүгнэвэл үнэнд тун сайн нийцэж байх шиг санагдаж байна.

АНХНЫ УНШИГЧИД

Бид Үйл явдал номыг МЭ-ний 70 оноос өмнө бичсэн гэдгийг нэгэнт ойлгосон тулд уг номын түүхэн орчингийн хоёр дахь хэсэг болох Луухын бүтээлийн анхны уншигчид руу анхаарлаа хандуулцгаая. Үйл явдал номоор дамжуулан Луухын хүрэхийг хичээж байсан уншигчдын талаар мэдэж авах нь түүний энэ бүтээлийг ойлгоход тун чухал юм.

Бид Үйл явдал номын анхны уншигчдыг хоёр аргаар судлах болно. Эхлээд бид уг номыг Тёфил гэгч хүнд зориулсан тухай илэрхий баримтыг судлана. Хоёрдугаарт, энэ номыг бас өргөн олон уншигчдад зориулсан байж болох боломжийг судлана. За одоо бүгдээрээ Луухын анхны уншигч болох Тёфилийн тухай судалцгаая.

Теофил

Луухын бичсэн оршил хэсгээс харвал Тёфил бол түүнд энэ үүргийг өгсөн ивээн тэтгэгч болох нь мэдэгддэг. Бид Луухын сайн мэдээний 1-р бүлгийн 3-р ишлэл болон Үйл явдал номын 1-р бүлгийн 1-ээс Луух энэ хоёр бүтээлээ Тёфил гэдэг хүнд зориулсан болохыг харсан. Луух Тёфилийг “Эрхэм хүндэт Тёфил” гэсэн байдаг. Энэ “эрхэм хүндэт” гэсэн үгийг Грекээр “кратистос” гэдэг бөгөөд хүндлэн

дээдэлж байгаагийн илэрхийлэл ажээ. Энэ үг нь олон хүнийг Тёфилийг маш баян ивээн тэтгэгч байсан гэж бодоход хүргэдэг.

Гэвч Луух болон Тёфил нарын хоорондын харилцаа нь зөвхөн нэг ивээн тэтгэгчийн холбоог бодвол илүү ойр дотно байсан. Луухын сайн мэдээ болон Үйл явдал номыг уншвал Тёфил нь Луухын сурагч байсан нь харагддаг. Бид Луух, Тёфил хоёрын харилцааны энэ талыг Луухын сайн мэдээний оршил хэсгээс харж болно.

Луухын 1-р бүлгийн 3-аас 4-т:

Гүнээ хүндэт Тёфил ээ! . . . Би олон жил үүнийг сайн судалсан учраас сонссон бүхэн чинь үнэн болохыг танд ойлгуулахыг зорьж, тун сонирхолтой нэгэн өгүүлэлийг дэс дараалан бичиж өгье. Миний бичих зүйл гэвэл, . . . (Луух 1:3-4).

Энэ хоёр ишлэлээс харвал зарим талаараа Луухын бичсэн ном нь Тёфилийн өмнө нь сонсож мэдсэн бүхэн дээр үндэслэж бичсэн болохыг харуулж байна. Товчхон хэлэхэд Луух Тёфилд заавар өгөхийн тулд бичжээ.

Луух Тёфилийг өөрийн анхны уншигч гэдгээ тодорхой хэлсэн явдал бидэнд түүний анх уншигчид хэн болох талаар арай өргөн хэмжээнд харахад тусалж байна.

Өргөн олон уншигч

Бид Шинэ Гэрээний хаанаас нь ч уншсан 1-р зууны үеийн Христэд итгэгчид Үйл явдал номонд Луухын хөндөн бичсэн олон асуудлыг шийдэх гэж чармайж байсныг төвөггүй олж хардаг. Луухын бичсэн түүхэнд Еврей болон Еврей бус итгэгчдийн хоорондын зөрчил, өөр өөр төлөөлөгч болон багш нарын удирдлагаас болсон хуваагдлийн талаар өгүүлдэг. Мөн түүний номонд хуурамч багш нарын танилцуулсан алдаатай сургаалийг хүртэл хөндсөн байдаг билээ. Христийн сүм ба иргэний засаг захиргааны хоорондох зөрчлийг бас өгүүлдэг. Эмэгтэйчүүд болон ядууст анхаарлаа хандуулсан байдаг. Энэ номонд хатуу ширүүн хавчлага, зовлон зүдгүүр, шорон гяндангийн тухай ч гардаг. Христийн сүмүүд байгуулагдсаныхаа дараах арав гаруй жилийн турш дээрх олон асуудлыг шийдэхийг хичээж байсан учраас л Үйл явдал номонд онол сургаал, ёс суртахуун болон бодит амьдралын бэрхшээлүүдийн талаар өгүүлсэн байдаг юм.

Нэгэнт л Луух Үйл явдал номонд маш олон янзын асуудлын талаар өгүүлсэн учраас тэрбээр өөрийнхөө энэ бүтээлийг олон янзын итгэгчдийг уншихад зориулж бичсэн гэж үзэх үндэслэл байна. Тэрбээр Тёфил болон эхэн үеийн итгэгчдэд тулгарч байсан олон хэцүү асуудлыг даван туулахад нь туслах бодолтой байжээ.

Нийгмийн байдал

Ийнхүү бид Үйл явдал номыг бичигдсэн он болон анхны уншигчдын талаар

ойлголттой болсон болохоор гуравдахь сэдвээ үзэхэд бэлэн боллоо. Энэ бол Үйл явдал номыг бичиж байх үеийн дэлхий буюу Луухын бүтээлд гарч буй нийгмийн ерөнхий байдал юм. Бид Луухын амьдарч байх үеийн нийгмийн хүчин зүйлсийн талаар илүү ихийг ойлгох тусмаа түүний номын олон онцлох шинжийг ухаарах болно.

Бид 1-р зууны үеийн амьдралын гол хоёр онцлог шинжийг мэдэж авч байж л Үйл явдал номонд гарах нийгмийн байдлын талаар судлах болно. Эхнийх нь Ромын Эзэнт улсын захиргаа ба эрх мэдэл. Харин удаах нь Христийн сүм ба Еврейчүүдийн хоорондын шинэ харилцаа юм. Эхлээд бүгдээрээ Ромын Эзэнт улсын талаар судлацгаая.

Ромын Эзэнт улс

Луухыг Үйл явдал номоо бичиж байх үед Ромын Эзэнт улс нь Газрын Дундад тэнгисийн эргэн тойрны бүх улсыг эзлэн захирч, улмаар өнөөгийн Англи улс, хойд Африк болон Азийн зарим хэсгийн хяналтандаа оруулсан байв. Эхэн үеийн Христийн сүмүүд байгуулагдаж байх үед энэ эзэнт улс улам өргөжин тэлж, олон ард түмэн газар нутгийг эзэмшилдээ оруулж байлаа. Ингэх тусмаа л тухайн эзэлж авсан улс орныхоо нийгмийн бүхий л талбарт Ромын өвөрмөц үнэт зүйлс, бодлого зорилго, итгэл үнэмшил гүнзгий нөлөө үзүүлэх болов. Мэдээж Ромчууд эзлэн авсан нутаг дэвсгэрийнхээ төр засаг болон эдийн засагт маш их нөлөө үзүүлсэн гэдэгт ямар ч эргэлзээгүй итгэж болно. Ромын Эзэнт улсын төр засгийн нэг чухал ажил бол эзэлж авсан нутаг дэвсгэрийнхээ орон нутгийн удирдлагыг хүчээр хянаж тухайн газар нутагт амар амгалан үнэнч шударга байдлыг тогтоож байсан явдал юм.

Эзлэгдсэн улс үндэстэнүүдэд орон нутгийн өөртөө засах эрх өгсөн боловч тэдний засаг захиргааг ихэвчлэн дахин өөрчлөн байгуулдаг байлаа. Тэд үргэлж Ромын шатлан захирах захиргаан дор байдаг байв. Жишээлбэл, Үйл явдал номонд Цезаре хотод амьдардаг Фээлих, Порхфээст хэмээх Ромын хоёр захирагчийн тухай өгүүлдэг. Тэд Цезаре хотоос Иудей нутгийг бүхэлд нь захирдаг байв. Тэд татвар хураахаас гадна өөрсдийн хариуцаж буй Ромын Эзэнт улсын нутаг дэвсгэртээ амар тайван байдал, эмх журмыг сахиулах үүрэг хүлээсэн байлаа. Мөн Ромын эзэнт улс нь эзлэн авсан нутаг дэвсгэрийнхээ хүн амын дунд өөрсдийн иргэдээрээ дамжуулан улс төр, соёлынхоо нөлөөг тогтоож байв.

Заримдаа Ромын засаг төр чөлөөнд гарсан цэргийн албан хаагчдыг шинэхэн эзлэгдсэн нутаг дэвсгэртээ суурьшуулдаг байлаа. Үүнээс болоод бүх Эзэнт улс даяар Ромын үнэнч иргэд тал талаасаа харийн иргэдээр хүрээлүүлж амьдрах болов. Гэсэн хэдий ч тэд тухайн нутагт амьдарч байхдаа албан харилцаанд ч, энгийн олны дунд ч Ромын үнэт зүйлсийг сурталчилж, эх орондоо үнэнч байдаг байв. Тийм учраас л Үйл явдал номонд Ромоос ирсэн хүмүүсийн тухай дахин дахин дурдсан байдаг юм. Бид Үйл явдал номын 2-р бүлгийн 10-аас 11-т буюу бүр Пэнтээхест баярын тухай өгүүлсэн хэсгээс л “Ром хотоос . . . ирсэн хүмүүс” (Бидний зарим нь Иудейчүүд, зарим нь өөр үндэстэн) гэж бичсэнийг уншсан. Мөн Үйл явдал номын 10-р бүлэгт Ертөнцийн Эзэнийг эмээн хүндэлдэг Ромын зуун цэргийн дарга Хорнел гэгчийн тухай гардаг бөгөөд энэ хүн Христийн тухай сайн мэдээ түгэн тарахад маш

чухал үүрэг гүйцэтгэсэн тухай уг номонд дурдсан байдаг.

Үүнээс гадна тухайн орон нутгийн соёлд зам харгуй, уран барилга, уулзалтын газар зэрэг Ромын захиргаанаас хийж хэрэгжүүлсэн олон нийтийн байгууламж их нөлөө үзүүлсэн юм. Ромын засаг захиргааны энэ тал нь Пууль болон бусад хүмүүс авралын зарын ажлаа чөлөөтэй, аюул осол багатай хийж чадсаны тайлбар болж өгнө. Төлөөлөгчид нэг газраас нөгөө рүү аялаж Христийн тухай сайн мэдээг тунхаглаж байхдаа эдгээр олон нийтийн зориулалттай барилга байшинг бас ашигладаг байв.

Ромчууд эзлэн авсан улс орныхоо шашин шүтлэгт нөлөөлж байсан нь эхэн үеийн Христийн сүмүүдэд ч бас тохиолдож байлаа.

Луухыг энэ номоо бичиж байх үед Ромын Эзэнт улсын анхаарлын төвд нэг л хүн байсан. Тэр бол Цезарь юм. Эзэн хаан буюу Цезарыг зөвхөн өөрийн хүмүүс нутаг орныхоо эзэн бус, ард олны Аврагч буюу чөлөөлөгч бурхан гэж үздэг байв. Ромчуудын суртал нэвтрүүлгийн дагуу бол Цезарууд нь ард түмнийг эмх цэгцгүй байдал болон харанхуйгаас чөлөөлсөн ажээ. Ромын Эзэнт улсыг тэлнэ гэдэг нь түүний авралыг өргөжүүлж, хүмүүсийг өөрсдийнх нь улс орны харгис хатуу хаадаас чөлөөлж, Ромын сайхан сэтгэлт хаадын дор аваачих явдал байлаа.

Эзлэгдсэн улс орны ихэнх газарт ард олныг өөрсдийн шашиныхаа зан үйлийг үргэлжлүүлэхийг зөвшөөрч байсан боловч тэднээс Цезарын бүхнээс илүү чанар болон Ромын уламжлалт бурхдыг хүлээн зөвшөөрөхыг шаардаж байлаа. 1-р зуунд амьдарч байсан ихэнх Иудейчүүд мөн Христэд итгэгчид Ромын ноёрхолд хүндэтгэлтэй хандаж байв. Харин бат итгэлтэй Иудейчүүд болон Христэд итгэгчид Ромын шашин хамгийн дээд гэдэг үзлийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байлаа. Ромын Эзэнт улс Иудейн шашиныг религио лисита буюу хууль ёсны шашин гэж үзэж байв. Харин тэд Иудей болон Иудей бус хүмүүсийг аль алийг нь хавчин хяхаж байсан ч Христэд итгэх итгэлийг нь хүлцэн тэсвэрлэж байлаа. Нэгэнт л Ромчууд засаг захиргаа, хүн ам, олон нийтийн байгууламж, шашин шүтлэгийг нь хянаж байсан учраас өөрсдийнхөө шашины нөлөөг хаа сайгүй тараахыг хичээж байсан юм.

Ийнхүү бид Ромын Эзэнт улсын сүр хүч нөлөөтэй холбогдуулж тухайн үеийн нийгмийн байдлыг судаллаа. Одоо харин бид Луухын бичиж байсан тухайн үеийн нийгмийн байдлын өөр нэг чухал талыг үзэхэд бэлэн боллоо. Энэ бол Үл итгэгч Иудейчүүд ба эхэн үеийн Христийн сүмийн хоорондын харилцаа юм.

Иудейчүүд

Бид Иудейчүүд болон эхэн үеийн Христийн сүмийн харилцааны талаар авч үзэхдээ эхлээд тэдний хоорондох *гүнзгий холбоо*, дараа нь тэдний хоорондын *үндсэн ялгааг* судлах болно. За одоо бүгдээрээ энэ хоёр бүлгийн хоорондын холбоог судалж эхэлцгээе.

Эхэн үеийн Христийн сүм нь Иудейчүүдтэй адилхан нийтлэг нэг өв уламжлалыг дагадаг байв. Нэг зүйл тун тодорхой байдаг. Бид өнөөгийн энэ ертөнцөд Есүс бол Еврей хүн байсан гэдгийг, Түүний төлөөлөгчид бүгд Еврей хүн байсныг, мөн эхэндээ Христийн сүм нь бараг бүхэлдээ Еврейчүүдээс бүрдэж байсан гэдэг баримтыг үргэлж өөрсөддөө сануулж байх хэрэгтэй. Тэгэхлээр эхэн

үеийн Христэд итгэгчдийн бодолд Ертөнцийн Эзэний амласан Еврей Аврагчид үнэнч байна гэдэг нь зарим талаараа Иудейн шашинд тууштай байх утгыг агуулж байсан нь тийм ч гайхмаар зүйл бишээ.

Үйл явдал номонд бичсэнээр бол эхэн үеийн сүмийн олон хүн Иерусалим дахь Ертөнцийн Эзэний сүмийн хүндэтгэлийн хуралд оролцож, Еврейн хурлын танхимуудад сууж Бичээсээс сонсож, Иудейчүүдийн олон ёс заншилд талархалтай ханддаг байлаа. Жишээ болгож, Үйл явдал номын 13-р бүлгийн 32-т буй Пуулийн үгийг сонсоцгооё:

Ертөнцийн Эзэн хожим өөрт нь итгэсэн хүмүүст нэгэн сайн юм хийж өгөх ам өчгийг бидний өвөг дээдэст өгсөн байжээ. Тэгээд бидэнд Есүсийг илгээж амласан тэр үгээ биелүүлэв (Үйл явдал 13:32-33).

Пууль болон түүнтэй хамт явж байгаа хүмүүс Еврейчүүдийн хурлын танхимд өөрсдийгөө тэдэнтэй адилтгаж байсан бөгөөд эртний өвөг дээдсээ “бидний өвөг дээдэс”, харин бид нартай адил Христэд итгэгчдийг “тэдний үр хүүхдүүд” гэж хэлж байв.

Нэмж хэлэхэд, эхэн үеийн Христийн сүм болон Иудей хүмүүс нэг ижил Бичээсийг хэрэглэдэг байлаа. Үйл явдал номонд бичсэнээр бол Христэд итгэгчид сайн мэдээг Иудейн орчин нөхцөлд тунхаглаж байхдаа Бичээс рүү хандахыг цаг үргэлж уриалж байсан байна.

Пууль Иудейчүүдэд Христийн тухай тунхаглаж байхдаа Бичээс рүү хэрхэн хандаж байгааг Үйл явдал номын 17-р бүлгийн 1-ээс 3-д ингэж бичжээ. Тэнд Луух:

Пууль, Силас хоёр Амфиполь, Аполиониа хотоор ороод Тесалоник хотод ирлээ. Пууль заншил ёсоороо гурван долоо хоногийн турш бямба гариг бүр Иудейчүүдийн хурлын танхимд очиж, Ертөнцийн Эзэний сургаалыг уншиж, тайлбарлан, илгээсэн аврагч Христ нь тамлуулан алагдахад Ертөнцийн Эзэн дахин амилуулах ёстой байсныг батлан, 'Есүс бол Ертөнцийн Эзэний илгээсэн тэр аврагч мөн' гэдгийг ойлгуулдаг байв (Үйл явдал 17:1-3).

Үүнээс гадна Христэд итгэх итгэл ба Иудейн шашины хооронд гүн гүнзгий холбоо байсан нь Иудейн эрх баригчдыг Христийн сүмтэй нэлээд өргөн харилцахад хүргэсэн байна.

Үйл явдал номонд бичсэнээр бол эхэн үеийн итгэгчид Христийн тухай сайн мэдээг зоригтойгоор тунхаглаж байсан нь тэднийг олон удаа Иудейн эрх баригчидтай зөрчилдөхөд хүргэж байжээ. Гэвч Христэд итгэгчид Иудейн удирдагчдыг аль болохоор хүлээн зөвшөөрч, Ертөнцийн Эзэний тушаалыг зөрчихыг шаардах үед л тэднийг эсэргүүцдэг байв.

Иудей хүмүүс болон эхэн үеийн Христийн сүмийн хооронд байсан ийм гүн гүнзгий холбоог үл харгалзан тэдний хоорондын үндсэн ялгааг олж харж болохоор байв.

Христэд итгэгчид ба Христэд үл итгэгч Иудейчүүдийн хооронд хамгийн эхний бөгөөд гол үндсэн ялгаа нь Христийн хувь хүний мөн чанар болон Түүний хийсэн ажил үйлс байв. Христийн сүм нь Есүс бол үхлийг ялан дийлсэнээс гадна,

үхлээс дахин амилсанаараа мөхөж байсан бүх бүтээлийг эргээд сэргээж эхэлсэн гэж тунхаглаж байлаа. Харин үл итгэгч Иудейчүүд болохоор тэдний дунд ирнэ гэж Ертөнцийн Эзэний амласан Аврагч нь гэмт хэрэгтэнтэй адил загалмай дээр цовдлуулж нас барах ёсгүй гэж үзэж байсан. Энэ ялгаатай үзэл л Христэд итгэгчид болон Христэд үл итгэгч Иудейчүүдийн хооронд өнөөгийн бидний үе хүртэл үргэлжилж буй зөрөлдөөнийг бий болгосон юм.

Хоёрдугаарт, эхэн үеийн Христэд итгэгчид болон Иудуйн эрх баригчид Еврей Библийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрч байсан ч үүний зөв тайлбар, ялангуяа Есүстэй холбоотой хэсгийг тайлбар дээр маш хүчтэй зөрөлдөж байлаа. Христэд итгэгчид Еврей Библид өгүүлдэг удахгүй ирэх Аврагчийн тухай найдвар нь Есүст бүрэн биелсэн гэдэгт итгэж байсан бол үл итгэгч Иудейчүүд энэ ойлголтыг үгүйсгэж байв. Иудейн шашины олон бүлэг янз бүрийн үзэл бодолтой байсан ч, ихэнх нь Есүсийг Хуучин Гэрээнд өгүүлсэн Аврагчийн тухай найдварыг биелүүлсэн гэж хүлээн авах нь боломжгүй гэж үзэж байв.

Гуравдугаарт, эхэн үеийн Христэд итгэгчид болон 1-р зууны үеийн Еврейчүүд Еврей бус хүмүүсийг хэрхэн үзэж байгаагаараа ялгаатай байлаа. Ихэнхдээ шашинаа хатуу сахигч Еврейчүүд, Еврей бус хүмүүстэй нөхөрлөдөггүй байжээ. Гэхдээ хөвч хөндүүлээгүй Еврей бус олон хүн Иудейн шашины итгэл үнэмшил, ёс суртахууны сургаалд маш их татагдаж орон нутгийнхаа Иудейн хурлын танхимтай холбоотой байдаг байсан бөгөөд тэднийг Ертөнцийн Эзэнээс эмээн хүндэтгэгчид гэдэг байлаа. Ертөнцийн Эзэнээс эмээн хүндэтгэгчдийг бусад Иудей бус хүмүүсээс илүү их хүндэлдэг байсан боловч тэд Иудейн олон түмний бүрэн эрхт гишүүн байгаагүй юм. Эдгээр Иудей бус шүтлэгтэнүүд Иудейн шашинтан болохын тулд усаар угаалгах, хөвч хөндүүлэх, Иудейн ёс заншлыг хатуу сахих гэх мэтийн ёслол үйлддэг байжээ.

Христэд итгэгч анхны Еврейчүүд Еврей бус хүмүүсийн талаар эхлээд дээрхтэй адил ойлголттой байсан боловч Христийг дагаж буй Еврей бус хүмүүс бол Христийн сүмийн бүрэн эрх гишүүн юм байна гэдэг ойлголтонд аажмаар хүрсэн байна. Анхны итгэгчид Ариун Сүнснээс шинэ илчлэлтийг хүлээн авсаны үр дүнд аливаа хүн Христэд итгээд, гэмээ хүлээн зөвшөөрч, усан баталгаа хийлгэсэн байх нь Христийн сүмийн гишүүн болоход хангалттай гэдэг шийдэлд хүрчээ. Ийнхүү энэ бүхнийг Есүсийн төлөөлөгчид Иудей болон Иудей бус хоёр бүлгийн хүмүүсийн дунд Христ бол Орчлон Ертөнцийн Их Эзэн гэдэг сайн мэдээг тунхаглахдаа ажил хэрэг болгож байлаа. Тэд итгэгчдийн тоо өсөх тусам дээрх хоёр бүлгийн хүмүүсийн хандив болон үйлчлэлийг хүлээн авч байсан. Ертөнцийн Эзэн Хуучин Гэрээний үед өөрийн ард түмний дунд хаант улсаа өргөжүүлэн тэлж байсан тэр л найдвараа бүрэн биелүүлэхийн тулд Еврей бус хүмүүсийг ашиглаж байгааг тэд ойлгожээ. Тиймээс энэ бүхэн Есүст үл итгэгч Еврейчүүд болон Христэд итгэсэн анхны хүмүүсийн хооронд олон зөрчил гаргахад хүргэсэн явдалд гайхах зүйлгүй байхаа.

Тэгэхлээр бид Үйл явдал номыг Луух бичсэн цаг хугацаа, хэнд зориулж бичсэн болон тухайн үеийн нийгмийн байдлын талаар зарим нэг нарийн ширийн зүйлийг мэдэж авах нь уг номыг судлахад их хэрэг болно. Ингэснээр бид Луухын дэвшүүлсэн асуудалд талархалтай хандаж, тэрбээр тэр бүхнийг хэрхэн шийдэж байгааг ойлгож, өнөөгийн амьдралдаа яаж хэрэгжүүлэх талаар илүү сайн бэлтгэгдэх болно.

ТЕОЛОГИЙН ҮНДЭС СУУРЬ

За ингээд бид Үйл явдал номын зохиогч болон түүхэн орчинг судалсан болохоор одоо энэ хичээлийнхээ гуравдахь гол сэдэв болох уг номын *теологийн үндэс суурийг* үзэхэд бэлэн боллоо.

Ер нь Үйл явдал номыг судалж байхад бидний толгойд теологийн маш олон асуулт орж ирдэг. Луух теологийн ийм үзэл санааг хаана сурсан юм бол? Номондоо юуг оруулж, юуг хасахаа яаж шийдэв ээ? Зохиолоо бичиж байхдаа бүхнийг хамарсан ямар зарчим баримтлав? гэх мэтийн олон асуулт гарч ирдэг. За харин энэ бүх асуултын хариултыг Луухын баримталж байсан теологийн үндэс сууриас олж мэдэж болно.

Үйл явдал номын теологийн үндэс суурийн тухай бидний яриаг гурван хэсэгт хувааж болох юм. Нэгдүгээрт, бид Луухын теологийн үндсийг Хуучин Гэрээнээс судлана. Хоёрдугаарт, Ертөнцийн Эзэний илгээсэн Аврагчийн байгуулах Ер бусын Хаант улсын тухай Луухын итгэл үнэмшил нь түүний теологид хэрхэн нөлөөлснийг авч үзнэ. Гуравдугаарт, Луухын бүтээлүүдийн эхний боть болох Сайн мэдээний ном нь Үйл явдал номд өгүүлсэн мэдээлэлийг ойлгоход бидэнд хэрхэн тусалж байгааг харна. За одоо эхлээд Үйл явдал номын Хуучин Гэрээний үндсийг үзэцгээе.

Хуучин Гэрээ

Луухын зохиолд Хуучин Гэрээ наад зах нь хоёр янзаар нөлөөлсөн байна. Юуны өмнө түүхийг үзэх Хуучин Гэрээний үзэл Луухад маш гүнзгий нөлөөлжээ. Хоёрдугаарт, ялангуяа Израйлийн түүхэнд хандах хандлага түүнд маш их нөлөөлсөн байна. Одоо бүгдээрээ түүхийг ерөнхийд нь үзэх Хуучин Гэрээний үзлийг Луухын теологид хэрхэн өгүүлж байгааг харьцгаая.

Түүх

17-р зууны үеийн Христэд итгэгч философич Блэйз *Паскал* өөрийн суут бүтээл “*Пэнсэс*” буюу “Бодлууд” зохиолдоо түүхийн туршид хүн төрөлхтний ухааран ойлгосон гурван агуу үнэнийг өгүүлсэн байна. Нэгдүгээрт, орчлон ертөнцөд шингэсэн гайхамшиг, бүх бүтээлийн яруу алдар гоо үзэмжийг дурджээ. Учир нь Ертөнцийн Эзэн бүх зүйлийг тун сайхан бүтээсэн юм. Хоёрдугаарт, тэрбээр орчлон ертөнцийн анхны яруу алдар болон одоогийн зовлон зүдгүүр ялзрал сүйрлийн хоорондын учир нь олдохгүй зөрчлийн талаар өгүүлдэг. Харин гуравдугаарт, Паскал энэ зөрчлийн шийдэл болж чадах аврал болон найдварын тухай өгүүлсэн байдаг.

Паскалын энэ эргэцүүлэл нь Хуучин Гэрээнд дэлхийн түүхийг бүтээл, хүн гэмд унах болон аврал гэсэн гурван гол хэсэгт хуваасан явдалтай мөр зэрэгцэж байна. Харин Луух Үйл явдал номонд Христэд итгэсэн анхны хүмүүсийн тухай өгүүлэхдээ түүхийг авч үзсэн энэ гурван талт үзэл бодлыг тусгасан байдаг.

Бүтээлийн үеийн тухай авч үзье л дээ. Эхлэл номын 1-р бүлэгт Ертөнцийн Эзэн энэ дэлхийг ер бусын улсынхаа үргэлжлэл байхаар бэлтгэсэн байна. Тэрбээр орчлон ертөнцийг эмх цэгцтэй болгох зарлиг буулгаж, Эдэн цэцэрлэгийг аз жаргалтай газар болгож, үүн дотроо Хаан дүр төрх нь болсон хүмүүсийг байрлуулсан билээ. Мөн хүмүүсийг үржин олширч, Эдэн цэцэрлэгээс эхлээд энэ гаригийн өнцөг булан бүрд очиж суурьшиж, газар дэлхийг захир гэж тушаасан юм. Товчхон хэлэхэд Ертөнцийн Эзэн газар дэлхий дээр хаант улсаа байгуулах бүрэн хөгжлийн үе шатыг тогтоож өгсөн байна.

Хуучин Гэрээний энэ чухал санааг Луух ойлгосон болох нь Үйл явдал номын олон хэсэгт илэрхий байдаг. Жишээлбэл 4-р бүлгийн 24-өөс 30-р ишлэлд Пэтр, Иоган хоёр “Бүх бүтээл бол Ертөнцийн Эзэн энэ газар дэлхийн хаан” болохын нотолгоо болох талаар өгүүлсэн байдаг. “Бүх бүтээл бол Ертөнцийн Эзэн улс үндэстэнүүдийг захирах үндэс болдог” тухай Пууль, Барнаб хоёр 14-р бүлгийн 15-аас 17-д өгүүлдэг. Ертөнцийн Эзэн газар дэлхийг гишгүүрээ болгож бүтээсэн гэж Стефан 7-р бүлгийн 49-д нотолжээ. Бүгдээрээ Үйл явдал номын 17-р бүлгийн 24-өөс 27-д буй Пуулийн Афин хотод хэлсэн үгийг сонсоцгооё:

Хорвоо ертөнц хийгээд түүнд орших бүх юмыг бүтээсэн аугаа их хүчит эзэн бол Ертөнцийн Эзэн юм. . . Тэр Их Эзэн эрт нэгэн хүнийг бий болгож, даян дэлхийн бүх үндэстнийг тэр хүнээс эхлэн үүсгэсэн байна. . . Ертөнцийн Эзэн өөрийг нь хүмүүс хүсэмжлэн хайж олоод, ойр дотно болохыг хүсжээ (Үйл явдал 17:24-27).

Энд бичсэнээр бол Сайн мэдээг тарааж буй Пуулийн үйлчлэл нь бүх талаараа Бүтээлд хандсан байна. Ертөнцийн Эзэн бол хорвоо ертөнц хийгээд түүнд орших бүх юмыг бүтээсэн аугаа их хүчит эзэн юм. Тэрбээр орчлон хорвоог эмх цэгцтэй бүтээгээд өөрийг нь хүмүүс хүсэмжлэн хайж олохыг хүссэн. Пуулийн үйлчлэл орчлон хорвоог анх бүтээхдээ Ертөнцийн Эзэний тавьсан зорилготой нийцэж улам өргөжиж байна. Луух энэ бүгдийг номондоо бичсэнээрээ эхэн үеийн Христийн сүмийн талаарх ойлголтонд нь бүтээлийн тухай сэдэв чухал байсныг үзүүлжээ.

Мөн үүнтэй адил хүн гэмд унасан талаарх Луухын ухаарал Үйл явдал номын ерөнхий агуулгад багтсан байдаг. Ертөнцийн Эзэн анхны хүмүүс болох Адаам Хаваах хоёрыг бүтээсний дараа тэд Түүнийг эсэргүүцсэн гэдгийг бид Эхлэл номын 3-р бүлгээс уншсан билээ. Энэ явдал асар их нөлөө үзүүлэв. Хуучин Гэрээнд бичсэнээр бол анхны хоёр хүн нь хорвоо дэлхийд маш чухал үүрэгтэй байв. Гэвч тэд гэмд унаснаар хүн төрөлхтнийг үхлийн хараал дор аваачиж, бүх бүтээлийг доройтуулан гажуудуулсан юм.

Хүний гэмээс болсон зовлон зүдгүүрийн тухай Үйл явдал номын турш олон газар өгүүлдэг. Бид хүн гэм хийж унасан талаар 2-р бүлгийн 38, 3-р бүлгийн 19-д буй Пэтрийн хэлсэн үгнээс, 5-р бүлгийн 29-өөс 32-т буй төлөөлөгчид Иудейчуудын ахлагч нарын зөвлөлийн өмнө итгэлээс хамгаалж үг хэлж буй хэсгээс, 20-р бүлгийн 18-аас 35-д буй Эфэс хотын ахлагчдын өмнө Пуулийн хэлсэн үг болон 26-р бүлгийн 20-д Агрип хааны өмнө түүний хэлсэн үгнээс тус тус уншдаг билээ.

Хүн гэмд унаснаас болоод бодит дэлхий ертөнц, бидний эдийн засгийн бүтэц, улс төрийн тогтолцоо түүгээр ч барахгүй Христийн сүм хүртэл зовж зүдэрч

байгаа талаар Үйл явдал номонд дахин дахин дүрсэлдэг.

Аз болоход Луух зөвхөн бүтээл болон хүн гэмд унасан талаарх Хуучин Гэрээний сургаалд итгэхээс гадна авралын тухай тэнд өгүүлсэн бүхнийг хүлээн авсан хэмээн Үйл явдал номонд бас хэлсэн байдаг. Гэм хүн төрөлхтнийг болон бүх бүтээлийг аймшигтайгаар сүйтгэсэн ч, Ертөнцийн Эзэн орчлон хорвоог ямар ч итгэл найдваргүй үлдээгээгүй юм.

Гэм анх энэ дэлхийд орж ирсэн цагаас эхлээд Ертөнцийн Эзэн хүмүүсийг гэмийн хараалаас аварч, чөлөөлж байсан тухай Хуучин Гэрээ заадаг. Түүгээр ч барахгүй Хуучин Гэрээний зөнчид гэмийн хараал бүх бүтээлээс бүрмөсөн арилах өдрийг ч хүртэл урьдчилан хэлсэн байдаг. Луух Үйл явдал номондоо дээрх гэмийн хараалаас аврах үйл явц нь энэ дэлхийд Христийн хийсэн авралын үйлсээр дамжин ирж байгаа талаар өөрөө юу гэж үздэгээ дахин дахин харуулсан байдаг билээ. Энэ сэдэв Үйл явдал номын турш гардаг.

Бид гэмийн хараалаас аврагдах тухай өгүүлсэн хэдэн сэдэв олсноо доор жагсаан бичлээ. Эдгээр нь 2-р бүлгийн 21-ээс 40-д буй Пэтрийн сургаал, 5-р бүлгийн 29-аас 32-т буй Иудейчуудын ахлагч нарын зөвлөлийн өмнө Есүсийн төлөөлөгчид итгэлээ хамгаалж үг хэлсэн хэсэг, 11-р бүлгийн 14-т Хорнелд хандан хэлсэн ер бусын элчийн үг, 13-р бүлгийн 23-д Писидийн Антойч хотын хурлын танхимд Пуулийн хэлсэн үг, 15-р бүлгийн 7-оос 11-д Иерусалимын зөвлөлийн өмнө Пэтрийн хэлсэн нотолгоо болон 16-р бүлгийн 30-31-д Филипой хотын шоронгийн харгалзагчид Пууль Силас хоёрын хэлсэн үг зэрэг юм.

Луух Үйл явдал номыг бичиж байхдаа дэлхийн түүхийг авч үзэх Хуучин Гэрээний үзлийн нөлөөнд гүнзгий автагдсан байсан гэдгийг бид уг номонд хандахдаа үргэлж санаж байх хэрэгтэй. Тийм учраас л тэрбээр 1-р зууны үед дэлхийн түүхийг бүхэлд нь авч үзэхдээ орчлон ертөнцийг анх бүтээсэн үеэс эхлээд хүн гэмд унасан болон Христэд буй аврал зэргийг дахин дахин дурдсан ажээ.

Ийнхүү бид түүхийг Хуучин Гэрээнд хэрхэн авч үзсэн талаар ерөнхийд нь авч үзлээ. Харин одоо тэнд Израйлийн түүхийг хэрхэн авч үзэж байгаа болон ялангуяа энэ онцгой ард түмний түүхээс Үйл явдал номонд буй Луухын тэмдэглэл хэрхэн хамаарч байгааг судлахад бэлэн боллоо.

Израйль

Луух Үйл явдал номыг бичиж байхдаа Израйлийн түүхтэй үй олон шижимээр холбогдсон байдаг. Харин бид үүнийг дүрслэн харуулахын тулд энэ яриагаа Израйлийн түүхэнд гарсан гурван гол үйл явдлаар хязгаарлах болно. Эдгээр нь Ертөнцийн Эзэн Аврахаамыг сонгон авсан түүх, Мөшэхээр удирдуулсан их нүүдэл болон Давидын хаант улс байгуулагдсан явдал юм. Эхлээд бүгдээрээ Ертөнцийн Эзэн Аврахаамыг хэрхэн сонгосон тухай Луухын бичсэн түүхэнд хэрхэн бичсэнийг авч үзэцгээе.

Эхлэл номын 12-р бүлгийн 1-ээс 3-т Ертөнцийн Эзэн Аврахаамыг энэ онцгой ард түмний өвөг дээдэс болгон сонгосон тухай өгүүлж байна. Тэнд:

Нэгэн удаа Мөнхийн Эзэн Авраамд хандан, “Чи өөрийн болон эцгийнхээ ойр холын садан төрөл бүгдийг орхин нутгаасаа гарч

миний зааж өгөх оронд очиж суурьшсугай. Би чамаас эхлэн өнөр өтгөн аугаа их улс бий болгож, чамайг баяр баясгалантай өөдрөг, нэр алдартай хүн болгож өгөх учраас чамаас болж хожим нь бас олон хүнд баяр баясгалан ирнэ. Чамайг ерөөсөн хүнийг би ерөөнө. Харин чамайг хараасан хүнийг би хараана. Чамаар дамжуулан би орон бүхний ард түмнийг аз жаргалтай болгоно” гэжээ (Эхлэл 12:1-3).

Эдгээр ишлэлд бичсэнээр бол Ертөнцийн Эзэн хоёр том зорилгын улмаас л Аврахаамыг Амлалтын нутаг руу явуулахаар дууджээ.

Нэг талаар бол Аврахаам асар их нэр хүнд олж нэгэн аугаа үндэстний өвөг дээдэс болоод оюун санааны болон эд материалын олон ивээл хүртэж байна. Аврахаам болон түүний үр удамд Ертөнцийн Эзэний үзүүлсэн ивээл бол энэ аажмаар уруудан сүйрч буй хорвоо дэлхийд Түүний өгөх аврал гэсэн найдвар байгааг бэлгэдэн үзүүлсэн юм.

Нөгөө талаар Ертөнцийн Эзэний дуудлага нь Аврахаам болон түүний удам угсааныханд бодож байснаас нь ч ихийг өгөх байлаа. Аврахаамаар дамжуулан *орон бүхний ард түмнийг аз жаргалтай болгох* ажээ. Аврахаам болон түүн удам угсаа дэлхийн бүх гэр бүлд Ертөнцийн Эзэний ивээл хүрэх суваг нь болсон юм.

Аврахаамыг сонгох болсон Ертөнцийн Эзэний сонголтын энэ хоёр тал бол Үйл явдал номонд буй Луухын үзэл бодлын гол суурь нь болсон байна. Аврахаамын удам угсаа болсон Еврейчүүд Христээр дамжуулан хэрхэн аврагдаж, Израйлийн энэ аугаа өвөгт амласан Ертөнцийн Эзэний амлалт биелэгдэж байгааг Луух олон удаа өгүүлсэн байдаг.

Мөн Луух Христэд итгэгч Еврей хүмүүс Христийн тухай сайн мэдээг Еврей бус хүмүүст хүргэж байгаад бас анхаарлаа хандуулжээ. Филип, Пэтр, Пууль, Барнаб гэх мэтийн Еврей хүмүүс энэ авралын сайн мэдээг Еврей бус улс орнуудад хүргэж байгаа талаар Луух Үйл явдал номонд дахин дахин өгүүлсэн байдаг. Энэ бүхэн мөн Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний амлалтын биелэл юм.

Хоёрдугаарт, Үйл явдал номонд буй Луухын үзэл бодлоос Мөшэх болон Христийн сүмийн хоорондын харилцааны талаарх ойлголт нь харагддаг. Ертөнцийн Эзэний чөлөөлөгчийн хувьд Мөшэх Израйльчуудыг Египетийн боолчлолоос удирдан гаргаж, улс үндэстэндээ Түүний хуулийг танилцуулж, даган биелүүлэх үүрэг хариуцлагатай болгодог. Мөшэх Түүний хуулийг буулгасан номондоо хэзээ нэгэн цагт Ертөнцийн Эзэн өөртэй нь адил нэг зөнчийг энэ дэлхийд илгээж өөрийн ард түмнийг гэмийн боолчлолоос чөлөөлөх тухай зөгнөсөн байна. Харин Луух Үйл явдал номонд энэ Мөшэхтэй адил зөнч гэдэг нь Есүс мөн гэж заасан билээ. Стефаны хэлсэн үгийг Луух Үйл явдал номын 7-р бүлгийн 36-аас 39-д хэрхэн бичсэнийг сонсоцгооё:

. . . 'Ертөнцийн Эзэн намайг та бүхэнд илгээсэн. Хожим миний адил нэгэн зөнчийг бас илгээнэ. Энэ хүн яг та нарын дундаас гарна' гэж Мөшэх Израйльчуудад хэлсэн аж. Мөшэх тийнхүү цөлд бидний өвөг дээдэс Израйльчуудын хамт байлаа. . . Мөшэх Ертөнцийн Эзэний мөнхийн сургаалийг сонсож, бидний хойч үеийн төлөө тэр сургаалийг дамжуулж өгсөн юм. Гэтэл нэгэн удаа Мөшэхийг Синай ууланд гарсан хойно бидний өвөг дээдэс түүний үгнээс татгалзан

басамжилж, Египет оронд буцахыг хүсжээ (Үйл явдал 7:37-39).

Стефаны үзэл бодлоор бол Есүс нь Мөшэхийн урьчилан хэлсэн тэр зөнч мөн ажээ. Тэгэхлээр Есүсээс татгалзана гэдэг нь эртний Израйльчуудтай адил Мөшэх болон Ертөнцийн Эзэний Хуулиас татгалзаж байгаатай адил болж байна. Харин Мөшэх болон Ертөнцийн Эзэний Хуульд бүрэн захирагдана гэдэг нь Христийг хүлээн авна гэсэн үг билээ. Үйл явдал номын 28-ийн 23-д Иудейчүүдийн ахлагч нарт Пуулийн хэлсэн үгийг Луух хэрхэн хураангуйлан бичсэнийг авч үзье:

Болзсон тэр өдөр олон Иудей хүн Пуулийн гэрт ирэв. Пууль тэдэнд өдөржин шахуу Ертөнцийн Эзэний ер бусын улсын тухай ярьж, тайлбарлан өгч, дээр үед Мөшэхийн бичсэн Ертөнцийн Эзэний хууль болон түүний зөнчдын номноос иш татаж, Есүст итгүүлэхийг хүсэв (Үйл явдал 28:23).

Пууль болон эхэн үеийн Христэд итгэгчдийн хувьд Мөшэх мөн Ертөнцийн Эзэний Хуулийг хүлээн зөвшөөрөх нь Христэд итгэх итгэлийн үндсэн суурь болж байна. Энэ итгэл Луухыг Үйл явдал номоо бичихэд нь нөлөөлжээ.

Гуравдугаарт, Давидын хаант улсын тухай өгүүлсэн Хуучин Гэрээний хэсгүүд Луухад бас нөлөөлсөн байна. Луухын хувьд Давидын угсааныхан Израйль орныг захирах мөнхийн ноёрхолоо тогтоосон тухай өгүүлсэн сэдвээс илүү чухал сэдэв Хуучин Гэрээнд байна гэж төсөөлөхөд ч бэрх буй заа.

Хуучин Гэрээний үед Израйль нь хаант улс болон өргөжихөд Ертөнцийн Эзэн Давидын гэр бүлийг өөрийнхөө ард түмнийг удирдах угсаа болгон сонгосон. Мөн Хуучин Гэрээнд Давидын удам угсаа нь Ертөнцийн Эзэний хаанчлалыг Израйль орноос энэ дэлхийн өнцөг булан бүрд өргөжүүлэх өдрийг хүртэл урьдчилан хэлсэн байдаг.

Энэ тухай бид Дуулалын 72-р дууны 8, 17-р ишлэлүүдэд:

[Давидын хүү] нэг далайгаас нөгөө далай хүртэл, Евфрат мөрнөөс дэлхийн өнцөг булан хүртэл удирдан захирна. . . Түүгээр дамжуулан бүх үндэстэн ивээгдэх бөгөөд тэд түүнийг Ертөнцийн Эзэний ивээлийг хүртсэн хүн гэж дуудах болно (Дуулал 72:8, 17).

Дээрх ишлэлд илчлэн харуулсанаар бол өөрийнх нь удам болох Давидаар дамжуулан Аврахаам хүн төрөлхтөнд ивээлийг авчрах ёстой ажээ. Гэхдээ Давид энэ үүргийг өөрөө биелүүлээгүй. Харин нэг удам нь түүний нинжин сайхан сэтгэл амар тайван удирдлагаар бүх хүн төрөлхтнийг захирах хаан болох ёстой байсан юм.

Үйл явдал номонд Луух ийм итгэл найдварыг Давидын угсааныхаас олж хардаг. Тэрбээр Есүс бол Давидын хүү бөгөөд Христэд итгэгчидээр дамжуулан Ертөнцийн Эзэний ер бусын улсыг Иерусалим хотоос эхлээд энэ дэлхийн өнцөг булан бүрд Түүний ноёрхолыг тэлэх хаан удамт захирагч гэж ойлгосон байдаг. Жишээ болгож Үйл явдал номын 15-р бүлгийн 14-өөс 18-д Иерусалимын зөвлөлийн Яахообын хэлсэн үгийг сонсьё. Тэнд:

'Ертөнцийн Эзэн Иудей бус зарим хүнд аврал хайраа харуулж өөрийн болголоо' гэж Симонпэтр хэлсэн. 'Сонгож авсан Иудей бус хүмүүстээ өөрийгөө үзүүлэхийн тулд хожим би энэ дэлхийд ирнэ. Тэгээд эрт цагт Давид хаан байгуулж, одоо балгас болсон тэр сүмийг дахин босгоно гэж Их Эзэн сая хэллээ. Тэр энэ тухай зөвхөн одоо ч биш өнө эртнээс бидэнд мэдэгдэж байлаа' хэмээн Ертөнцийн Эзэний зөнчид бичжээ. Пэтрийн хэлсэн үгийг сонсож, Ертөнцийн Эзэний одоогийн хийж буй зүйлийг үзвэл дээрх үгс ёсоороо биелж байна (Үйл явдал 15:14-18).

Энд Яахооб Амос номын 9-р бүлгийн 11, 12-т Давидын хаант улсыг Ертөнцийн Эзэн сэргээж, хаанчлалыг нь Еврей бус улс орнуудад өргөжүүлнэ хэмээн зөгнөн хэлсэн үгийг дурдаж байна. Яахооб энд хэлсэнчлэн тэрбээр Еврей бус хүмүүсийн дунд Христийн тухай сайн мэдээг амжилттай тараах нь Хуучин Гэрээний дээрх найдварын биелэл болно гэдэгт итгэж байлаа.

Есүс бол Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний амлалтыг өвлөгч, Мөшөхтэй адил зөнч бөгөөд Давидын удмын эцсийн хаан мөн гэдгийг Луух уншигчиддаа ойлгуулахыг хүссэн юм. Хуучин Гэрээнд урьдчилан хэлсэнчлэн Есүс тэнгэрт одож хаан ширээнд залран, Иерусалим хотоос эхлээд энэ дэлхийн өнцөг булан хүртэл авралын хаант улсаа өргөжүүлж, өөрт нь итгэгчдийг олшруулж, Сайн мэдээг хаа сайгүй тунхаглан дэлхийг эзлэн авсан билээ.

ЕРТӨНЦИЙН ЭЗЭНИЙ ХААНТ УЛС

Ийнхүү бид Луух Хуучин Гэрээнээс ямар хамааралтай байсныг үзлээ. Тийм учраас Ертөнцийн Эзэний илгээсэн аврагчийн байгуулах ер бусын хаант улсын тухай ойлголт Үйл явдал номын теологийн үндэс суурьт ямар хувь нэмэр оруулсаныг үзэхэд бэлэн боллоо.

Ертөнцийн Эзэний хаант улсын тухай бидний яриа гурван хэсэгт хуваагдах болно. Нэгдүгээрт, бид 1-р зууны үед ихэд түгсэн Ертөнцийн Эзэний илгээх аврагчийн тухай Еврейн теологийг авч үзнэ. Хоёрдугаарт, бид Усаар угаан батлагч Жоганы теологид гол анхаарлаа хандуулна. Харин гуравдугаарт бид Луухын дэмжин сайшааж байсан Ертөнцийн Эзэний илгээх аврагчийн тухай Христэд итгэгчдийн теологийг дээрх үзэл бодлуудтай товчхон харьцуулна. За одоо бүгдээрээ энэ тухай Еврейн теологийн баримталдаг чиг хандлагын талаар үзэж эхэлцгээе.

Еврейн теологи

МЭӨ 5-р зууны үед Хуучин Гэрээний сүүлчийн номыг бичсэнийг дараа Израйль орон оюун санааны хувьд харанхуй байдалд орсон юм. Амласан нутгийн гадна болон эх орондоо амьдарч байсан Израйльчуудын олонхи нь харь орны захирагчдын харгис хэрцгий боолчлолд зовон зүдэрч байлаа. Тэднийг эхлээд Вавилончууд, дараа нь Перс Маадайн нэгдсэн улсынхан, тэгээд Грекчүүд, эцэст нь

Ромчууд захирч байв. Энэ урт удаан үргэлжилсэн зовлон зүдгүүрээс болж Ертөнцийн Эзэн Израйльчуудын дунд тэднийг харийн дарлалаас чөлөөлөх аврагчаа илгээнэ гэсэн найдвар нь Еврейн теологийн хамгийн чухал сэдэв болсон байна.

Аврагчийн тухай Еврейчүүдийн найдвар нь олон янзын чиглэлтэй байв. Жишээлбэл, Зелет бүлгийнхэн Ертөнцийн Эзэн Ромын эрх баригчдын эсрэг бослого хөдөлгөөнийг улам бүр ихэсгэснээр Аврагч ирэх боломжтой болгохыг хүсдэг гэж итгэж байлаа. Апокалиптик буюу удахгүй дэлхий сөнөж зөв шударга хүмүүс аврагдана гэж үздэг янз бүрийн бүлгүүд Ертөнцийн Эзэн ер бусын аргаар хөндлөнгөөс оролцож дайснуудаа устгаад Өөрийн ард түмнээ ялагч болгон тогтооно гэж итгэж байв. Мөн номист буюу итгэлийн амьдралаа юу хийж болох, юуг хийж болохгүй байх жагсаалтаар тодорхойлдог Паараш болон Садуух бүлгийнхэн байсан. Израйльчууд Ертөнцийн Эзэний хуулийг дуулгавартай дагахаас нааш Тэр тэдний амьдралд оролцохгүй гэж тэд үздэг байлаа. Луух Үйл явдал номын нэлээд олон хэсэгт Ертөнцийн Эзэний илгээсэн аврагчийн байгуулах хаант улсын тухай Христэд итгэгчдийн үзлийг олон Еврей хүн хүлээж авахгүй байгаа талаар дурдсан.

Хэдийгээр Еврейчүүд Аврагчийн тухай олон янзын найдвар тээж байсан ч Усаар угаан батлагч Жоганы үйлчлэлийн үеэр Еврейн теологид маш чухал шилжилт болсныг Луух ажигласан байна.

Усаар угаан батлагч Жоган

Луухын сайн мэдээнд ч, Үйл явдал номонд ч Жоган хүмүүсийг чин сэтгэлээсээ гэмт амьдралаа орхихыг уриалж, газар дэлхий дээр Ертөнцийн Эзэний хаант улс байгуулах Аврагчийн тухай сайн мэдээг тунхаглаж байгаа нь харагддаг. Үүнээс гадна Жоган Есүсийг Ертөнцийн Эзэний илгээсэн Аврагч мөн гэж зөв таньсан байдаг. Луухын сайн мэдээний 3-р бүлгийн 16, 17-д:

Жоган тэдэнд, 'Миний дараа надаас чухал нэгэн хүн ирнэ. Би тэр хүний шаахайг ч тайлах эрхгүй билээ. Би та нарыг зөвхөн усаар угааж өгсөн бол тэр хүн зарим нэгэнд чинь Ертөнцийн Эзэний Ариун Сүнснийг өгч, гэмээ цагаатгуулаагүй хүмүүсийг мөнхийн зовлонгийн халуун галд шатаах шийтгэл оноож чадна. Ийнхүү тэр хүн цайруулсан буудайг шигшүүрээр ялгаж, сайн буудайг авч, хальс хогийг мөнхийн галд хийж шатаах мэт ажил хийнэ' гэж хэлжээ (Луух 3:16-17).

Жоган энд Ертөнцийн Эзэний илгээсэн Аврагч асар их ивээл, мөн Түүний шийтгэлтэй цуг ирэх Ариун Сүнсний тусламжаар цэвэр ариун болгох үйлсийг хийнэ хэмээн зөв зүйтэй тунхаглаж байна. Гэхдээ тэрбээр энэ бүгдийг Аврагч нэгмөсөн хийх болно гэсэн буруу ойлголттой байв.

Түүний илгээсэн Аврагч энэ дэлхийд аврал болон шийтгэлийг үе шаттай авчрах болно гэдгийг Жоган урьдчилан харж чадаагүй. Сүүлд нь Жоган энэ Аврагчаас Еврейн теологичдын хүсэн хүлээж байсан бүхнийг Есүс биелүүлээгүй явдалд гайхаж будилдаг. Жоганы сэтгэл ихэд үймэрсэн тул тэрбээр Есүсээс үнэхээр

Ертөнцийн Эзэний илгээсэн аврагч мөн эсэхийг лавлахаар элч нараа явуулдаг. Одоо бүгдээрээ тэдний тавьсан асуулт болон Есүсийн өгсөн хариултыг Луух сайн мэдээнийхээ номын 7-р бүлгийн 20-иос 23-т хэрхэн бичсэнийг үзэцгээе. Тэнд:

Тэр хоёр Есүстэй уулзаж, 'Бид хоёрыг Жоганбаптис явуулав. Та Ертөнцийн Эзэний илгээсэн хүн үү? Эсвэл танаас өөр хүн ирэх ёстой юу?' гэж асуулаа. . . За одоо та хоёр Жоганбаптис очоод үзсэн, сонссоноо ярь! 'Одоо тэр сохрыг хараатай, доголныг хөлтэй, дүлийг сонсголтой болгож, хулгана яртныг ариутгаж, нас барагсдыг дахин амилуулж, энгийн дорой хүмүүст Ертөнцийн Эзэний гайхамшигт үнэнийг ярьж байна. Надад итгэсэн бүхэн асар их жаргалтай болно' гэжээ (Луух 7:20-23).

Жоганд өгсөн хариултандаа Есүс Ертөнцийн Эзэний илгээх аврагчийн тухай Исаиа номонд буй хэдэн зөгнөлийг битүүхэн дурдаж байна. Тэрбээр үүгээрээ Хуучин Гэрээнд өгүүлсэн аврагчийн тухай янз бүрийн зөгнөлийг бүгдийг нь хараахан биелүүлж амжаагүй ч заримыг нь биелүүлж байгаагаа Жоганд батлан хэлсэн юм. Аврагчийн хувьд хийж байгаа ажлаа олон түмэнд аажмаар ил болгож байгаагаас болоод зорилгоосоо няцахгүй байхыг Есүс бас Жоганд уриалж байна.

Товчхондоо, Аврагчийн хувьд хийж буй Есүсийн үйлчлэл нь олон түмэнд хүсэн хүлээж байснаас нь огт өөрөөр харагдаж байв. Олон зуун жилийн өмнө оршиж байсан Давидын хаант улс шиг Аврагчаар удирдуулсан хаант улс газар дэлхий дээр агшин зуур байгуулагдана хэмээн Еврейчүүд найдаж байлаа. Харин Есүс газар дэлхий дээр үйлчилж байхдаа иймэрхүү хаант улсыг байгуулах гэж огт оролдоогүй юм.

Ийнхүү бид Еврейн теологийн ийм ойлголт, мөн Усаар угаан батлагч Жоганы үзэл бодлыг мэдсэн учраас Аврагч болон Ертөнцийн Эзэний хаант улсын тухай эхэн үеийн Христэд итгэгчдийн теолгитой танилцахад бэлэн боллоо.

Христэд итгэгчдийн теологи

Луухын бичсэн ном болон Шинэ Гэрээний бусад хэсгээс Ертөнцийн Эзэний илгээх Аврагчийн талаар Христэд итгэгчдийн теологи нь Христийн тухай сайн мэдээтэй нягт холбоотой байдаг. Бид Шинэ Гэрээнд буй Сайн мэдээг дараах байдлаар хураангуйлж болно:

Сайн мэдээ гэдэг нь Аврагч болох Есүсийн онцгой мөн чанар болон үйлсээр дамжуулан газар дэлхий дээр Ертөнцийн Эзэний хаант улс байгуулагдаж байгааг зарлахыг хэлнэ. Тэгээд энэ бүхэн Есүсийг Аврагч гэж итгэж хүлээн авсан хүнд Ертөнцийн Эзэн авралыг зөвшөөрч өгсөнөөр бүрэн гүйцэд болдог.

Сайн мэдээ нь маш чухал хоёр санааг хөнддөг гэдгийг та нар анзаарах хэрэгтэй байх. Нэг талаар бид Христийн тухай сайн мэдээний илүү объектив мөн чанар гэж хэлж болох хэсгийн тухай олж мэднэ. Есүсийн онцгой мөн чанар болон

үйлсээр дамжуулан газар дэлхий дээр Ертөнцийн Эзэний хаант улс байгуулагдаж байна. Аврагч болох Есүс нь газар дэлхий дээр Ертөнцийн Эзэний хаант улсыг байгуулах ажлынхаа төгсгөлийн үеийг эхэлсэн бөгөөд Тэрбээр нэгэн өдөр эргэж ирснээр эхэлсэн энэ ажлаа дуусгана гэдэгт Луух итгэж байлаа.

Нөгөө талаар Шинэ Гэрээнд буй сайн мэдээ нь илүү субъектив шинжтэй байдаг. Энэ нь Есүсийг Аврагч гэж итгэж хүлээн авсан хүнд Ертөнцийн Эзэн авралыг зөвшөөрч өгсөнөөр бүрэн гүйцэд болж Түүний хаант улсыг байгуулах ажил үргэлжилдэг. Христийн тухай сайн мэдээнд итгэсэн хүмүүсийн зүрх сэтгэл өөрчлөгдөж, Есүсийн авчирсан авралыг хүлээн авах бүр Ертөнцийн Эзэний хаанчлал энэ дэлхий дээр улам бүр тэлж байдаг юм.

Луух Үйл явдал номонд Сайн мэдээний энэ хоёр талд хоёуланд нь анхаарлаа хандуулсан байдаг. Объектив мөн чанарын хувьд бол Христээр дамжин ирсэн Ертөнцийн Эзэний агуу их авралын бодит талыг онцолсон байна. Өөрт нь итгэсэн хүмүүсийн төлөө Есүс алагдаж, улмаар үхлээс дахин амилж, Ертөнцийн Эзэн Эцгийнхээ баруун гарт заларч байгаа бөгөөд хожим яруу алдраа дуурсган энэ дэлхийд эргэж ирнэ хэмээн Христэд итгэгчид тунхаглаж байгаад Луух бичиж үлдээжээ.

Жишээлбэл, Луух Пэтрийн хэлсэн үгийг Үйл явдал номын 22-р бүлгийн 22-оос 24-т хэрхэн бичсэнийг сонсоцгооё. Тэнд:

Ертөнцийн Эзэн Назар хотын Есүсээр та нарын дунд гайхамшигийг бүтээлгэж, олон ер бусын баталгаа үзүүлэн, түүнийг илгээсэн болохоо харуулсаныг та нар мэднэ. . . Та нар түүнийг модон загалмайд цовдлуулав. Есүсийг үхэл дийлэх ёсгүй байсан учир Ертөнцийн Эзэн дахин амь оруулсан (Үйл явдал 2:22-24).

Пэтр сайн мэдээг тунхаглаж байхдаа Аврагчийн амьдрал, үхэл, дахин амилалт зэрэг объектив буюу бодит талыг нь дурдаж байгааг та нар анзаарсан байх.

Мөн Луух Христийн тухай сайн мэдээний илүү субъектив буюу хийсвэр талд анхаарлаа хандуулсан байдаг. Тэрбээр хүмүүс Христийн тухай үнэнийг хувьчлан хүлээн авах нь ямар чухал болохыг, үр дүнд нь тэдний амьдрал өөрчлөгдөж байгааг олон газар дурдсан билээ.

Жишээлбэл, “Пэнтээхөст” баярын үеэр Пэтрийн хэлсэн үгийг бичсэн Үйл явдал номын 2-р бүлгийн 37-оос 39-д ийм үгс байна.

Тэнд байсан хүмүүс Пэтрийн энэ үгийг сонсоод сэтгэл догдлон, 'Нөхөд өө! Бид одоо яах билээ?' гэж асуулаа. 'Гэмт амьдралаа орхиж, Есүс-Христэд итгэснээ баталж, усан баталгаа хийлгэгтүн! Тэгвэл Ертөнцийн Эзэн гэмийг чинь уучилж, Ариун Сүнсээ бэлэг болгон өгнө' (Үйл явдал 2:37-38).

Христийнхэний сайн мэдээг сонссон хүмүүсийн сэтгэл хөдөлж догдолжээ. Энэ бол зөвхөн баримтыг хүлээн зөвшөөрсөн хэрэг бус, Аврагчийг чин зүрхнээсээ, амьдрал байдлаа үндсээр нь өөрчлөхөөр хүлээн авч буй явдал байлаа.

1-р зууны үеийн Еврейн теологи нь Аврагч ирээд л шууд газар дэлхий дээр хаант улсаа байгуулна гэж итгэдэг байсан тухай бид үзсэн. Харин Есүс болон түүний төлөөлөгчид итгэгчдийн тоо өсөж, хүмүүс хувьчлан өөрчлөгдсөнөөр

Аврагчийн хаант улс нь аажмаар өргөждөг тухай зааж байсан.

Тийм учраас сайн мэдээг тунхагласны үр дүнд үл итгэгчид Есүст итгэж өөрчлөгдөж байгаа асуудалд Луух маш их анхаарал хандуулсаны нэг шалтгаан энэ юм. Ийм л арга замаар Ертөнцийн Эзэний илгээсэн Аврагчийн байгуулах ёр бусын хаант улс энэ дэлхийд өргөжин тэлэх ажээ.

За ингээд бид Хуучин Гэрээний ерөнхий зураглалыг санаандаа буулгасан тул Үйл явдал номын теологийн үндэс суурийн гурав дахь талыг үзэхэд бэлэн боллоо. Үүний уг үндэс нь Луухын бичсэн сайн мэдээнд байдаг юм.

ЛУУХЫН БИЧСЭН САЙН МЭДЭЭ

Ер нь бид Үйл явдал номыг уншиж байхдаа энэ бол Тёфил гэдэг хүнд Луухын бичсэн хоёр боть номын хоёр дахь нь юм шүү гэж үргэлж санаж байх хэрэгтэй. Луух үргэлж хүмүүс энэ хоёр номыг хамтад нь уншина гэж бодож байсан. Түүний бичсэн сайн мэдээний ном бол нэгэн том түүхийн эхний хэсэг, харин Үйл явдал ном нь уг түүхийн удаах хэсэг юм. Тийм учраас бид Үйл явдал номыг зөв ойлгохын тулд Луухын сайн мэдээнд өгүүлсэн тухайн түүх нь дараагийн номонд хэрхэн үргэлжилж байгааг ойлгох нь чухал.

Луухын сайн мэдээ нь биднийг Үйл явдал номыг ойлгоход олон талаар тусалдаг. Харин бид зорилгоосоо шалтгаалаад Ертөнцийн Эзэний ер бусын хаант улсын тухай сэдэв уг хоёр ботид хэрхэн үргэлжилж байгааг анхаарах болно. Луухын сайн мэдээнд Есүс Ертөнцийн Эзэний хаант улсын загвар болон зорилгыг тогтоож өгөөд, дээш одсоных нь дараа уг ажлыг хэрхэн үргэлжлүүлэхэд Өөрийн төлөөлөгчдөө бэлтгэдэг билээ. Харин Үйл явдал номонд Есүс тэнгэрт одсоныхоо дараа Өөрийнхөө төлөөлөгчдөд Ариун Сүнснийг туслагч болгон илгээгээд, Хаант улсаа Сайн мэдээгээр дамжуулан өргөжүүлэх ажлыг хариуцуулан өгдөг.

Бид Луухын бичсэн сайн мэдээ нь Үйл явдал номонд өгүүлсэн Ертөнцийн Эзэний хаант улсыг байгуулах ажилд Есүсийн төлөөлөгчдийг хэрхэн бэлтгэж байгаа хоёр арга замыг авч үзнэ. Нэгдүгээрт, бид уг хаант улсыг бий болгох үйлсийг Есүс эхлүүлсэн болохыг үзнэ. Хоёрдугаарт, Есүсийг тэнгэрт одсоны дараа уг хаант улсыг байгуулах ажлыг үргэлжлүүлэхийн тулд Түүний төлөөлөгчид ямар үүрэг гүйцэтгэж байгааг судлана. Одоо бүгдээрээ газар дэлхий дээр Ертөнцийн Эзэний ер бусын хаант улсыг байгуулах үйлсийг эхлүүлсэн Есүсийн тухай үзэцгээе.

Есүс

Луух өөрийн бичсэн сайн мэдээний номынхоо туршид Есүсийг Ертөнцийн Эзэний удахгүй байгуулах хаант улсыг тунхаглах зөнч, улмаар Өөрийн хүч чадлаар тэнгэрт одож уг ер бусын улсынхаа хаан ширээнд залрах хаан гэж тодорхойлсон юм. Есүс ч өөрөө ийм санааг олон газар хэлсэн байдаг. Бид үүнийг дүрслэн үзүүлэхийн тулд олон түмний дунд хийж байсан үйлчлэлийнхээ үеэр Есүсийн дурдсан хоёр тохиолдлыг л авч үзэх болно.

Эхнийх нь Луух номын 4-р бүлгийн 43-т Есүс олон түмний дунд хийх

үйлчлэлийнхээ эхэнд хэлсэн үг юм. Тэнд:

Ер бусын улсынхаа тухай гайхамшигт үнэнийг тунхаглуулахын тулд
Ертөнцийн Эзэн намайг илгээсэн (Луух 4:43).

Удаах нь, Есүс олон түмний дунд хийж байсан үйлчлэлийнхээ төгсгөл үед Иерусалим хотод хаан гэж зарлагдаж сүр жавхлантай орохын өмнөхөн арван лан мөнгөний тухай сургаалт үлгэр ярьсан тухай Луух номын 19-р бүлгийн 12-оос 27-д байдаг. Тэрбээр энэ сургаалт үлгэрээрээ ер бусын хаант улс нь хэрхэн аажмаар бий болох тухай тайлбарладаг. Харин тухай үеийн олон Еврей хүн уг хаант улсыг хоромхон зуур бүрэн гүйцэд байгуулагдана гэж үзэж байжээ. Гэвч Есүс уг хаант улсыг аажмаар үе шаттай байгуулна гэж заасан юм. Тэрбээр хаант улсаа байгуулж эхэлсэн ч, дахин энэ дэлхийд ирж хаант улсаа бүрэн гүйцэд байгуулж, тэргүүндээ титмээ өмсөх хүртэл нэлээд урт хугацаа шаардлагатай байна. Луух номын 19-р бүлгийн 11, 12-р ишлэлд энэ арван лан мөнгөний тухай сургаалт үлгэрийн эхлэлийг хэрхэн бичсэнийг үзэцгээе. Тэнд:

Есүс нийслэл хот Иерусалимд дөхөж очиход, 'Одоо тэр Ертөнцийн Эзэний улсыг байгуулах нь' хэмээн хүмүүс бодов. Үүнээс болж Есүс сургаалт үлгэр хэлсэн нь, 'Нэгэн тайж тамга тэмдэг хэргэм цол бүхий засаг ноён болох санаатай байлаа. Хэргэм цол авахын тулд тэрээр гадаадад очих хэрэгтэй болжээ' (Луух 19:11-12).

Энд юу болж байгааг анзаараарай. Есүсийг Иерусалим хотод ороход Түүнийг хаан гэж тунхаглах ёстой байв. Харин яг тэр үед хүмүүс “Есүс одоо өөрийгөө газар дэлхий дээрх нэгэн хаант улсын захирагч гэж өргөмжлөх нь” гэж бодохыг огт хүсээгүй юм. Үүний оронд Тэрбээр хаан хэргэм цолоо авахын тулд хаа нэгтээ удаан хугацаагаар явах бөгөөд ирээдүйд нэгэн өдөр газар дэлхий дээр хаант улсаа удирдахаар эргэж ирэх ажээ.

Яг ийм явдал болсон билээ. Есүс Иерусалим хотод баривчлагдаж модон загалмайд цовдлуулсан. Дараа нь Тэрбээр үхлээс дахин амилж тэнгэрт одсон. Энэ үедээ Ертөнцийн Эзэн Эцгээсээ хаан цолыг хүлээн авсан. Гэхдээ Тэрбээр хэзээ нэгэн цагт энэ дэлхийд эргэн ирээд ер бусын улсаа байгуулж дуусна.

Ийнхүү бид Есүсийг Ертөнцийн Эзэний ер бусын хаант улсыг байгуулахаар ирсэн гэдгийг ойлгуулах зорилгоор Луухын сайн мэдээг бичсэн гэдгийг ойлголоо. Тэгвэл одоо уг Сайн мэдээний хөндсөн хоёр дахь асуудлыг үзэцгээе. Энэ бол Сайн мэдээг тарааж уг хаант улсыг улам өргөжүүлэх үйлсэд Есүсийн төлөөлөгчдийн гүйцэтгэх үүрэг юм.

Төлөөлөгчид

Есүс модон загалмайд цовдогдохынхоо урд шөнө Ертөнцийн Эзэний ер бусын хаант улсыг байгуулах ажлыг нь үргэлжлүүлэн хийхийг Өөрийн төлөөлөгчдөд зааварчилдаг. Энэ талаар Түүний хэлсэн үгийг Луух номын 22-р бүлгийн 29, 30-д:

Ертөнцийн Эзэн ер бусын улсаа удирдах эрх надад өгсний адил би та нарт тусгай эрх өгнө. Тийм учраас миний ер бусын мөнхийн улсад та нар миний хамт хаан ширээнд сууж, хооллон ундалж, Израйлийн арван хоёр овог аймгийн хүмүүсийг захирна (Луух 22:29-30).

Есүс 12 төлөөлөгчөө ер бусын хаант улсынхаа захирагч шүүгч болгон томилсон аж. Тэдний ажил бол Ариун Сүнсний тусламжтайгаар Есүсийн үйлсийг цааш үргэлжлүүлж, ер бусын хаант улсын тухай сайн мэдээг тунхаглаж, энэ дэлхий даяар өргөжүүлэн тэлэхэд оршиж байлаа.

Тиймээс энэ ер бусын улс байгуулагдаж эхэлснийг албан ёсоор тунхаглах нь Есүсийн гол зорилго байсан бөгөөд тэнгэрт одоныхоо дараа уг ажлыг үргэлжлүүлэх үүргийг дагалдагч нартаа өгч байгаа зэргийг бид Луухын сайн мэдээнээс харж болох ажээ.

Харин Үйл явдал номыг Луухын сайн мэдээ яг дууссан хэсгээс цааш үргэлжлүүлэн бичсэн байдаг. Энэ ном нь Есүсийг нас бараад дахин амилж тэнгэрт одохоосоо өмнө дагалдагч нартайгаа хамт байж тэдэнд зааж сургаж байгаа тухай Луух өгүүлж эхэлдэг. Энэ тухай Луух хэрхэн өгүүлсэнийг Үйл явдал номын 1-р бүлгийн 3-аас 8-р ишлэлээс уншицгаая. Тэнд:

Есүс . . . алагдсан боловч . . . дахин амь орж, дөч хоногийн дотор төлөөлөгчдийнхөө өмнө олонтаа үзэгдэн . . . ер бусын улсын тухай ярьж, 'Ертөнцийн Эзэн та нарыг өөрийнхөө Ариун Сүнс тэй болгон баталж өгнө. Тийм учраас Иерусалим хотоос явалгүй түр байж, . . . тэр баталгааг хүлээгтүн' гэжээ. . . Нэг удаа төлөөлөгчид, 'Их Эзэн минь ээ! Одоо та Израйлийг Ромын хаант улсаас чөлөөлж, дахин биеэ даасан Израйль улсыг байгуулах уу?' гэж асуухад, 'Ертөнцийн Эзэн Эцгээс минь өөр хэн ч тэр үеийг тогтоохгүй. Харин түүний Ариун Сүнс та нартай нэгдэн асар их хүч чадал өгч Иерусалим хот, Иудей, Шомрон аймаг байтугай энэ дэлхийн өнцөг булан бүрд илгээн, миний тухай яриулах болно' гэж Есүс хэлэв (Үйл явдал 1:3-8).

Энэ ер бусын хаант улсыг агшин зуур байгуулагдана гэж харах хэрэггүй хэмээн Есүс дахиад л дагалдагчидаасаа хүссэн байна. Харин үүний оронд Өөрийнх нь төлөөлөгчид сайн мэдээг энэ дэлхий даяар тунхаглах үүрэг хүлээсэн гэдгийг баталгаажуулжээ. Яг үүнийг л Есүсийн төлөөлөгчид хийснийг Үйл явдал номонд өгүүлдэг. Тэд Ертөнцийн Эзэний ер бусын хаант улсын одоогийн хэлбэр болгож Христийн сүмүүдийг байгуулдаг. Тэд Христийн тухай сайн мэдээг шинэ газар нутаг, улс үндэстэнд хүргэж, уг ер бусын хаант улсыг Иерусалим хотоос эхлээд Иудей, Шомрон аймаг болон энэ дэлхийн өнцөг булан бүрд хүргэж өргөжүүлсэн билээ. Луух энэ бүхнийг хэрхэн дүгнэснийг үзэцгээе. Үйл явдал номын 28-р бүлгийн 30, 31-р ишлэлд:

Пууль хоёр жил байрны хөлс төлж, ирсэн бүх хүнийг хүлээн авч, Ертөнцийн Эзэний ер бусын улс болон Есүс Христ Их Эзэний тухай зоригтойгоор тунхаглахад хэн ч түүнийг хориглосонгүй ээ (Үйл

явдал 28:30-31).

Энд Луух Пуулийг зөвхөн “сайн мэдээ”-г заасан гэж хэлэхийн оронд “Ертөнцийн Эзэний ер бусын улс”-ыг тунхаглаж байсан гэж бичсэнийг ажиглав уу? Үйл явдал ном яг эхлэсэн шигээ төгсөж байна. Уг номонд Есүсийн төлөөлөгчдийн тунхаглаж буй мэдээгээр дамжин газар дэлхий дээр Ертөнцийн Эзэний ер бусын хаант улс өргөжин тэлж байгааг онцлон өгүүлжээ.

Тийм учраас бид Үйл явдал номонд хандахдаа Луух үүнийг Хуучин Гэрээний талаарх өөрийн ойлголт болон Христийн байгуулах Ертөнцийн Эзэний ер бусын улсын тухай 1-р зууны үеийн итгэл үнэмшил дээр тулгуурлан бичсэн гэдгийг үргэлж бодож байх хэрэгтэй. Мөн бид Үйл явдал ном бол Христийн үйлчлэлээс болж энэ ер бусын хаант улс байгуулагдах ажил хэрхэн эхэлсэн тухай өгүүлсэн Луухын сайн мэдээний үргэлжлэл бөгөөд Ариун Сүнсний тусламжтайгаар Есүсийн төлөөлөгчид болон эхэн үеийн итгэгчид энэ ажлыг цааш хэрхэн авч явж байгааг өгүүлсэн юм гэдгийг үргэлж санаж байх хэрэгтэй.

ДҮГНЭЛТ

Бид энэ хичээлээр Үйл явдал номын зохиогч хэн болохыг судалж, түүхэн орчинг тодорхойлж, мөн теологийн үндэс суурийг нь нарийвчлан судлан шинжиллээ. Энэ бүхнийг нарийн тодорхой мэдэж авах нь бидэнд Үйл явдал номын эх утгыг олж өнөөгийн амьдралдаа зөв хэрэгжүүлэхэд маань тус дэм болно.

Бид эдгээр цуврал хичээлийг үзэх тусам Үйл явдал номын үндэс суурь нь энэ гайхалтай номыг цааш судлах олон цонхыг нээж байгааг харна. Луух Ертөнцийн Эзэний тусламжтайгаар анхны итгэгчдийн тухай өгүүлсэн нь Тёфил болон бусад хүмүүсийг хэрхэн Христэд үнэнч итгэлтэйгээр үйлчлэхэд хүргэсэн талаар ч олж мэднэ. Мөн Үйл явдал ном нь биднийг өөрсдийнхөө эргэн тойронд Ертөнцийн Эзэний ер бусын хаант улсыг байгуулах сайн мэдээг тунхаглахад маань маш чухал удирдамжийг санал болгож байгааг ч харах болно.

Др. Ханс Ф. Байер (Host) is Professor of New Testament and Chair of the New Testament Department at Covenant Theological Seminary in St. Louis, Missouri. Dr. Bayer received his M.A. and M.Div. from Ashland Theological Seminary, and his Ph.D. from University of Aberdeen in Scotland. Born and raised in Germany, Dr. Bayer taught for ten years at the German Theological Seminary at Giessen, where he also planted and co-pastored a church. He lectures and preaches regularly throughout the U.S. and Europe and has published numerous English and German monographs, essays, dictionary articles, and commentaries, primarily on the Gospels and the Book of Acts. He is also the author of *A Theology of Mark: The Dynamic Between Christology and Authentic Discipleship* (P&R, 2012).

ТАЙЛБАР ТОЛЬ

Аврахаам – Хуучин Гэрээний эцгүүдийн нэг. Терагийн хүү. Израил үндэстэний эцэг. Эхлэл 15 болон 17 бүлэгт Ертөнцийн Эзэн энэ хүнтэй гэрээ байгуулж тоолж баршгүй олон үр удам, газар нутаг амласан юм

Маркионы эсрэг оршил үгс – Сайн мэдээний номуудын тухай бичсэн эртний баримт (МЭ 160-180). Энэ баримтаар сайн мэдээний бичээчдийг тодорхойлж, тэдний хувийн намтруудыг багтаасан байдаг

Апокалиптик ба апокалиптик үзэлтэн – 1-р зууны үеийн Еврей сургаалтны нэг урсгалд оноосон нэр. Тэд Ертөнцийн Эзэн ер бусын аргаар дайснаа дайран устгаж хаанчлалын цаг үеэ авчирна гэж итгэдэг байв

Александр хотын Климент – (МЭ 150-215) Александр хотод амьдардаг байсан эртний сүмийн эцэгүүдийн нэг, зохиолч

Давид – Хуучин Гэрээн дэх Израилын хоёр дах хаан. Түүний удам хаан ширээнд заларч үүрд мөнх хаачилах болно гэж Ертөнцийн Эзэн амласан

эвангелион ката Ионнан – “*Иоганы бичсэн сайнмэдээ*” гэсэн утгатай Грек үг

эвангелион ката Луакан – “*Луухын бичсэн сайнмэдээ*” гэсэн утгатай Грек үг

Евсевий – (МЭ 263-340) Христийн Сүмийн Түүх гэдэг зохиол бичсэн Христэд итгэгчдийн эртний сүмийн түүхч

Иосиф Флавий – (МЭ. 37-100) 1-р зуунд амьдарч байсан Еврей түүхч. Тэрээр “*Еврейн эртний түүхэн тэмдэглэл*” гэдэг зохиолоороо алдартай

кратистос – “Эрхэм хүндэт” гэсэн утгатай Грек үг. Энэ үгийг маш их

хүндтэй хүнд хэлдэг бөгөөд заримдаа Ромын амбан захирагчдыг ингэж дууддаг байв. Луух өөрий бичсэн Сайнмэдээ болон Үйл явдал номондоо Тёфилтэй ингэж мэндчилсэн байдаг

Луух – Гуравдах Сайнмэдээний ном болон Үйл явдал номыг бичсэн хүн. Христэд итгэгч Еврей бус хүн бөгөөд Пуулийн хамтран зүтгэгчдийн нэг. Эмч хүн байсан гэж үздэг

Мөшэх – Хуучин Гэрээний зөнч (эш үзүүлэгч) бөгөөд Израилчуудыг Египетээс чөлөөлсөн удирдагч. Ертөнцийн Эзэн түүнтэй “хуулийн гэрээ” байгуулсан. Тэрээр “Арван хуулийг” хүлээж авч Гэрээний Номыг Израилчуудад зориулан бичсэн. Есүсийн дүр хувирах мөчид Элигаахын хамт хүрэлцэн ирсэн хүн

Мураторигийн баримтын тасархай – Христийн сүм чуулганд хүлээн зөвшөөрөгдсөн Шинэ Гэрээний номуудыг жагсааж бичсэн хамгийн эртний баримт. МЭ 170-180 он

Неро – Христэд итгэгчдийг хавчиж байсан Ромын эзэн хаан (МЭ 54-68). Тэрээр 64 онд Ром хотод гарсан түймэрт Христэд итгэгчдийг гүтгэн буруутгасан. Пуулийг энэ хүн цаазалсан гэж үздэг

Папирус 75 – Луух болон Иоханы сайн мэдээний хэсгийг агуулсан хамгийн эртний гар бичмэл. МЭ 175-аас 200 оны хоорондах хуулбар гэж үздэг

Паараш – 1-р зууны үеийн Еврейн сургаалыг баримтлагч нэг урсгал. Тэд хуулийг хатуу барьж мөрддөг байснаараа нэртэй. Тэд Ертөнцийн Эзэн хүний дахин амилуулна гэж итгэдэг байсан. Харин Израилчууд Түүний хуульд бүрэн дуулгавартай болтол Ертөнцийн Эзэн юу ч хийхгүй гэж үздэг

Ром хот – Шинэ Гэрээний үеийн дэлхийн хамгийн хүчирхэг том эзэнт гүрний нийслэл. Пууль энэ хотод хоёр жил гаруй хоригдохдоо сайнмэдээг чөлөөтэй тунхаглаж байв

Төфил – Луух энэ хүнд Сайнмэдээний ном болон Үйл явдал номоо хаягласан байдаг

Зелөт бүлэг – 1-р зууны үеийн Еврей шашны нэг урсгал. Ертөнцийн Эзэний хаанчлал ирэхийн тулд Еврейчүүд Ромын эрх баригчдын эсрэг цэрэглэн хөдлөх ёстой гэж тэд итгэдэг байв